

12 дугаар сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдаан 12 дугаар сарын 10-ны өдөр хуралдаж аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, Аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг тус тус сонссоны зэрэгцээ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021 оны төсвийн төсөл, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө, аймгийн 2021 оны төсөв, аймгийн 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, ИТХ-ын хороодын бүрэлдэхүүн, ажиллах журам, Түр хамгаалах байрны харьяалал тогтоох тухай, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан байгуулах тухай, концуссын зүйлийн жагсаалт батлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн баталлаа.

б. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө төслийг нэгтгэн боловсруулж, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 12 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит 3 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолоор батлууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь иргэдийн эрэлт хэрэгцээг хангасан, ил тод, шуурхай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг үзүүлж, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах зорилгоор үйл ажиллагаандаа Чанарын менежментийн тогтолцооны "ISO 9001:2015" олон улсын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэн, баталгаажилтын аудитыг "Алсын зайнаас аудит хийх журам"-ын дагуу 12 сарын 28, 30-ны өдрүүдэд аудит хийлгэсэн ба "МонСертф" ХХК-ий тэргүүлэх аудитор П.Цэцэгмаа, аудитор Ю.Наранцацралт нар онлайнаар аудит хийж улмаар Сүхбаатар аймгийн ЗДТГ-ыг Чанарын менежментийн тогтолцооны "ISO 9001:2015" олон улсын стандартыг стандартын шаардлагын дагуу нэвтрүүлсэн тул баталгаажилтын гэрчилгээг олгуулах тухай санал, дүгнэлтийг гарган баталгаажилтын зөвлөлд хүргүүлэхээр болсон байна.

Түүнчлэн аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт сумдын ЗДТГ-т ЧМТ-ны "ISO 9001:2015" олон улсын стандартыг нэвтрүүлж, баталгаажилт хийлгэх зорилт, арга хэмжээг тусгасан ба Баруун-Урт, Дарьганга зэрэг сумд 2021 оны төсөвтөө энэхүү арга хэмжээг тусган хэрэгжүүлэхэд бэлэн болоод байна.

Аймаг, орон нутаг, салбарынхаа хөгжил дэвшил, хүн ардын сайн сайхны төлөө эзэмшсэн мэргэжил, авъяас билэг, хүч хөдөлмөрөө дайчлан, тогтвортой амжилт гаргаж хамт олноо хошуучлан ажилласан доорх нэр бүхий иргэдийг Сүхбаатар аймгийн 2020 оны "Салбарын тэргүүний ажилтан"-аар шалгаруулж, энгэрийн тэмдэг, мөнгөн шагналаар шагналаа.

1. Аймгийн "Төр захиргааны салбарын тэргүүний ажилтан"-аар Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дотоод ажил, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн Яринпилийн Эрдэнэхүү

2. Аймгийн "Боловсролын салбарын тэргүүний ажилтан"-аар Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн Англи хэлний багш Мижээгийн Бадрахцэцэг

3. Аймгийн "Соёл, урлагийн салбарын тэргүүний ажилтан"-аар Аймгийн хөгжимт жүжгийн театрын Морин хуурч, хөгжимчин Буджавын Тэгшжаргал

4. Аймгийн "Хууль зүй, тусгай чиг үүргийн салбарын тэргүүний ажилтан"-аар Аймгийн Онцгой байдлын газрын Аврагч, жолооч Ничинхүүгийн Батсуурь

5. Аймгийн “Санхүүгийн салбарын тэргүүний ажилтан”-аар Орон нутгийн өмчийн албаны ахлах мэргэжилтэн Болдын Даваадорж

6. Аймгийн “Эрүүл мэндийн салбарын тэргүүний ажилтан”-аар Аймгийн нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн эмч Ооёогийн Цэнгэлмаа

7. Аймгийн “Дэд бүтцийн салбарын тэргүүний ажилтан”-аар-“Дөрвөлж “ ОНӨҮГазрын ерөнхий инженер Чулуунсүхийн Алдарбат

8. Аймгийн “Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын тэргүүний ажилтан”-аар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Мөнх-Очирын Борчулуун

9. Аймгийн “Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний салбарын тэргүүний ажилтан”-аар “Хийморьт агшуун” ХХК-ний захирал Батбэхийн Урантуяа нарын хүмүүс тус тус шалгарлаа.

Цаг үеийн нөхцөл байдлын улмаас аймгийн удирдлагууд албан байгууллага дээр нь очиж шагнагдсан албан хаагч, иргэдэд шагналыг гардууллаа.

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 2020 оны 4-р улирлын байдлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайланг нэгтгэн танилцуулж байна.

Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад **13332** өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний **13205** өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт **97.3** хувийн үзүүлэлттэй байна. Хугацаа болоогүй **127** өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна.

2020 оны 4-р улирлын байдлаар Аймгийн Засаг даргад хандаж гаргасан 198 бичгээр болон Засаг даргын тамгын газрын нээлттэй утсаар ирсэн байна. Эдгээрээс 36 буюу 18,1 хувь нь гэр, халаалттай дулаан байр, эмчилгээний зардал, мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн өргөдөл байна.

Дэлхийн улс орнуудад дэгдэлт, тархац нь хурдтай өсөн нэмэгдэж, манай улсад ч Коронавируст халдвар “COVID-19”-ийн өвчлөл өсөн нэмэгдэж Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаа учраас гэр болон мөнгөн дэмжлэг, эмчилгээний зардал хүссэн иргэдэд мөнгөн дэмжлэг олгох боломжгүй байгаа учраас өргөдлийн хариуг тухайн үед нь тайлбарлан буцааж зайлшгүй шаардлагатай, амьдралын нөхцөл нэн ядуу 10 өрхөд гэр олгосон байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтэд тус тус Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг аймгийн ИТХ-д танилцуулан, биелэлтийг нэгтгэн хуралд өргөн барив.

Сум, агентлаг, төсөвт байгууллагын 2020 оны жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж боловсруулан цахимаар хүргүүлсэн ба ХШҮ-тэй холбоотой зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажилласан.

Төрийн албаны салбар зөвлөл: Аймгийн засаг даргын 12 дугаар сарын 24-ний өдрийн А/685 дугаар захирамжийн дагуу төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх болзлыг хангасан, төрийн захиргааны 5 албан хаагч аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд тангараг өргөлөө.

Төрийн үйлчилгээний удирдах 5 албан тушаалын сул орон тоон дээр шалгалт зохион байгуулж 6 иргэн өрсөлдсөнөөс шалгуур хангасан, тэнцсэн 5 албан хаагчийг томилуулах тухай саналыг ажлын байр зарлуулсан байгууллагуудад хүргүүлээд байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2020 оны 12 дугаар сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 42,382,2 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 9,507,6 сая төгрөгийн орлого орж нийт 51,889,8 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

12 сарын байдлаар улсын төсөвт 3,812,3 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,690,6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 70,6 хувиар, Орон нутгийн төсөвт 12,346,0 /Сумдууд орсон/ сая төгрөг төвлөрүүлэхээс 12,101,7 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 98,0 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 6,318,8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 45,424,0 сая төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан болно.

ОНХНС-ийн орлогын шилжүүлгийн гүйцэтгэл 12,579,7 сая.төгрөг үүнээс сумдад итгэлцүүрийн дагуу 3,864,3 сая.төгрөг хуваарилсан. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудын санхүүжилтийн гүйцэтгэл 5,655,4 сая.төгрөг, Удирдлагыг болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэл 1572,6 сая.төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 2 дугаар хуралдаанаар аймгийн 2020 оны төсвийн нэмэлт өөрчлөлтийг баталсантай холбогдуулан холбогдох чиглэлийг албан тоотоор сумдад хүргүүлсэн. Сумдын 2020 оны төсвийн тодотголын тогтоолыг хянан хүлээн авснаар төсвийн тодотголын өөрчлөлтийг байгууллага бүрээр төсвийн программд орууллаа.

Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд аймгийн 2021 оны төсвийн төсвийг боловсруулан 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3 дугаар хуралдаанаар аймгийн 2021 оны төсвийг хэлэлцүүлэн батлууллаа. 2021 төсөв батлах тухай тогтоол болон холбогдох тооцоог сумд байгууллагуудад албан бичгээр хүргүүлж, байгууллагуудын 2021 оны төсвийн хуваарийн саналыг авч ажиллалаа.

2021 оны төсөв батлах тухай сумдын тогтоолыг хянан хүлээн авч, эх үүсвэр, зарлага санхүүжилтийг тулган баталгаажуулснаар сумдын төсвийн орлого зардлын хуваарийн саналыг байгууллага бүрээр гаргуулан нэгтгэн хүлээж авлаа.

Байгууллага бүрээр батлагдсан төсвийн хүрээнд зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын зарцуулах эрхийн илүү дутууг хянаж, өссөн дүнгээр нийт дүн 51,3 тэрбум төгрөгний санхүүжилтийн эрхийг олгож ажилласан.

2020 оны 12 сарын байдлаарх байгууллагуудын өглөг авлагын нэгдсэн судалгаанд дүн шинжилгээ хийж, батлагдсан төсвийн хүрээнд зардал хооронд зохицуулалтуудыг хийж ажиллаа. Мөн цаг үеийн шинж чанартайгаар ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ, Шуурхай штабын хуралд тухай бүр оролцох, санхүү, нөөц бүрдүүлэх, шаардлагатай эм эмнэлэгийн хэрэгсэл, ариутгалын бодис татан авах тооцоо судалгааг боловсруулаж, тухай бүр Онцгой комиссын хуралд танилцуулан шаардлагатай хөрөнгө, нөөц бүрдүүлэн ажиллаж байна.

Орон нутгийн өмчийн газар: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/663 дугаар захирамжаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 64 нэр төрлийн 11,966,7 сая төгрөгийн төсөвтэй бараа, ажил, үйлчилгээ улсын төсвөөс эрх шилжиж ирсэн. 26 нэр төрлийн 10,288,5 сая төгрөгийн төсөвтэй бараа, ажил, үйлчилгээ нийтдээ 90 нэр төрлийн 22,255,2 сая төгрөгийн төсөвтэй бараа, ажил, үйлчилгээний тендер зарлахаас 87 нэр төрлийн 21,864,2 сая төгрөгийн төсөвтэй тендерийг зарласан. Зарлагдсан бүх тендерийг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, зарлагдсан бүх тендерийн урилга, үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайт, “Сүхбаатар

аймгийн орон нутгийн өмчийн газар” facebook хуудсанд ил тод байршуулж олон нийтэд мэдээлэлдэг.

Тухайн сард нийт 22,200,000 төгрөгийн 1 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг цахимаар зарласан бөгөөд шаардлагад нийцсэн оролцогч байхгүй.

Өмчийн бүртгэл, хяналтын хүрээнд: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчт эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу орон нутгийн өмчит 30 байгууллагаас ирсэн санал хүсэлтийг тухай бүр хариуг шийдвэрлэсэн.

Санхүүгийн хяналт, аудитын алба: Энэ сард аймгийн нийт Эмийн эргэлтийн сангийн 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Статистикийн хэлтэс: Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн баяжилт, шалгалтын ажлыг 12-р сарын 1-нээс 15-ны хооронд хийж сумдад заавар зөвлөмжийг өгч цаашид нягтлах чиглэл өгч 12-р сарын 31-ний өдрөөс хүлээн авч байна. Мөн хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээг 12-р сарын 25-ны өдрөөс хүлээн авч ажиллаж байна.

Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын 2020 оны тооллогыг 12-р сарын 18-наас 28-ны хооронд зохион байгуулан, хяналтын ажлыг 13 суманд 7 хэсэг гарган хийж 12-р сарын 29-ний өдөр дуусч шивэлтийн ажил 28-ны өдрөөс хийгдэж байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 12-р сарын мэдээллийг 7 сумын 12 нэгжээс 112 өрхөөс цуглуулалтыг хийж ажилласан. Мэдээлэл цуглуулалтыг 2020 оны 12-р сарын 15-ны хүртэл утсаар, 16-ны өдрөөс биечлэн очиж авч нэгтгээд байна.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлагийн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2020 оны А/85 дугаар захирамжаар зохион байгуулсан Угийн бичгийн уралдаанд оролцогчдыг шалгаруулж, шагнал гардуулах арга хэмжээг аймгийн ЗДТГ, Боловсрол, соёл урлагийн газартай хамтран зохион байгуулсан.

Угсаатны зүйн музей: Цагдаагийн газраас албан бичиг ирүүлсний дагуу бүртгэл мэдээллийн сан дахь булшны талаарх мэдээллийг нууцын зэрэглэлд шилжүүлсэн.

2020 онд шинээр бүртгэгдсэн СББӨТ-ийн судалгааг сумдаас авснаар энэ онд нийт 27 өв тээгч бүртгэгдэж 280 болсон.

Хөгжимт жүжгийн театр: Хөгжим ангийн бэлтгэлийн ерөөний засвар, тохилтын ажлыг дотоод нөөц боломжийн хүрээнд хийсэн.

Аймгийн онцгой комисс болон Хөдөлмөр халамж үйлчилгээнээс гаргасан шийдвэр, уриалгын дагуу байгууллагын 10 ажилтан албан хаагчдад хүнсний тусламж үзүүлсэн.

Нийтийн номын сан: Лавлагаа ном зүйн үйлчилгээний хүрээнд цахим хуудсаар нэг сарын хугацаанд 7240 удаа пост оруулан ажилласан байна.

Lib4U программ хангамж дээр ДДС ангиллыг ББК болгон солих ажлыг хянан ажиллаж шинээр төлөвлөгөө гарган ажиллаж Үндсэн фондын 170 гаруй номын ангилал сольсон.

Хүүхдийн уншлагын танхимд 31 ширхэг улавч оёж тогтмол ариутгал хийж, “Танин мэдэхүй” 25 ш номоор үзэсгэлэн гаргаж, 400 номны ББК ангилалыг сольж, каталогт орсон номны 200 зураг оруулсан.

Төсвөөр авсан 147 төрлийн 234 ширхэг 3.966.550 төгрөгийн номын жагсаалт гаргаж, хандиваар ирсэн 51 нэр тарлийн 72 ширхэг 1.114.200 төгрөгний номыг бүртгэсэн. Номын сангийн нэг бүрчилсэн бүртгэл буюу данс хуулах ажлыг 70-80% хуулж, жилийн эцсийн тооллого хийж дуусгасан.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 630 иргэнээс эмэгтэй 303, бүртгэлтэй ажилгүй иргэн 462 иргэнээс, эмэгтэй 221 иргэн байна. 1119 ажлын байрны

захиалга бүртгэгдэж, 847 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 529 иргэн буюу 62,3 % нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 843 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй 2 аж ахуй нэгж байгууллагын 135 гадаад/хятад/ажилтныг монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоход байгуулгын зүгээс дэмжих саналыг олгож, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллав.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 11 сарын 30-ний 07 тоот короновируст халдвар цар тахлын үед авч хэрэгжүүлэх тогтоолын дагуу сумдын мэргэжилтэн нарт мэдээлэл хүргэн ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөнд хамрагдах хүсэлтэй 15 иргэн, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацаа хойшлуулах хүсэлтэй 35 иргэн, “Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот” төслийн санхүүжилт авсан иргэдтэй холбогдон Баруун-урт сумын 4, Баяндэлгэр, Дарьганга сумдын 2 нийт 6 иргэний өөрсдийн хүсэлтээр эргэн төлөлтийн хувиарийг хойшлуулж гэрээг байгуулсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2020 оны 12 сарын 03-ний 1/1636 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, нэмэлт санхүүжилт, эргэн төлөлтийн хугацаа хойшлуулах хүсэлтэй иргэдийн судалгааг гарган ХХҮЕГ явууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлт 122 иргэний 42,682.2 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн авлагыг төвлөрүүлж программд оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нийгмийн халамжийн талаар: 2020 онд нийгмийн халамжийн орон нутгийн төсвөөс 115,546.0 мян. төгрөг төгрөгийг, улсын төсвөөс 9,682,166.0 мян. төгрөг нийт 9,806,712.0 мян төгрөгийг зарцуулагдахаар тусгагдсан байна.

2020 оны 12 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 3680000.0 мян.төг, тэтгэмжид 1107000.0 мян.төг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 767384.0 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 230000.0 мян.төг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөнд 480306.0 мян.төг, хүнс тэжээлийн хөтөлбөрт 1453816.0 мян.төг, алдарт эхийн одон 680200.0 мян .төг, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 31766,3 мян.төг, насны хишиг 415800.0 мян.төг, цалинтай эхийн тэтгэмж 164166.0 мян.төг, өрх толгойлсон эцэг/эхийн тэтгэмж 120721.0 мян.төг, ихэр хүүхдийн тэтгэмж 44000.0 мян.төг, орон нутгаас 115546.0 мян.төгрөгийн санхүүжилтийг авч арилжааны банкаар дамжуулан иргэдэд олгосон.

Е- халамж цахим системээр өргөдлөө гаргасан жирэмсэн эхийн тэтгэмж-70, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж-69, алдарт эхийн одонгийн 6, насны хишгийн 11 иргэний хүсэлтийг хүлээн авч, хянан баталгаажуулсан.

“Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг чанартай хүргэе” аяныг 10 дугаар сарын 22-ны өдрөөс 11 дүгээр сарын 13-ны хооронд хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд 232 өрхөд нөхцөл байдлын үнэлгээг сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдтэй хийж, Баруун-Урт сумын өрхүүдийг ХХҮГ-н ажлын хэсэг хэлэлцсэнээс нийт 66 өрхийн 288 иргэн, өрхдөө амьдрахгүй байгаа 19 иргэний үйлчилгээг 12 дугаар сард зогсоосон.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан Баруун-Урт сумын 653 өрхөд хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлж буй гэрээт 5 аж ахуйн нэгжид Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэнтэй хүнсний бүтээгдэхүүний нөөц, эрүүл ахуйн халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн мөрдөж байгаа, оочер дараалал үүсэж байгаа эсэхэд хяналт хийж зааварчилгаа өглөө.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралт сувиллын 19 дүгээр ээлжинд 12 ахмад настан амарч, бариа засал, төөнүүр, шарлага, бумба, зөгийн балны татлага, хаш чулуун ор, цахилгаан массажны аппарат зэрэг эмчилгээнүүдийг хийлгэсэн.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас "COVID-19" цар тахал, томуугийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хорио цээрийн дэглэмийн үед нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг хүнс тэжээлийн

дутагдлаас сэргийлэх, дархлааг нэмэгдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "FOOD BANK" аяныг аймгийн хэмжээнд 2020 оны 11-р сарын 18-ны өдрөөс 30-ний өдрийг хүртэл хэрэгжүүлсэн.

Сумдын тамгын газар, 308 иргэд, төрийн болон хувийн хэвшлүүд идэвхитэй оролцож 360 өрхөд 23574.8 мянган төгрөгний хүнсний бүтээгдэхүүн, түлээ түлш, ариун цэврийн хэрэгсэл, дулаан хувцас, маск, дархлааны витамин зэргийг хандивласан.

"FOOD BANK" аянд бусдыг манлайлан идэвхитэй оролцсон "Чандмань дэлгэр ундрах", "Хаан жимс" хүнсний дэлгүүр, "Эхэн-Ус" эмнэлгийн хамт олонд "ТАЛАРХАЛ" гардууллаа

Коронавирусын цар тахал Монголд гарсантай холбогдуулан бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 12 сард 1 удаа хуралдаж, ХНХЯ-ы сайдаас өгсөн албан чиглэлийн дагуу комиссын шийдвэрийн хугацаа дууссан 52 хүүхдийн асаргааны тэтгэмжийг 2 сараар сунгасан шийдвэрийг гаргасан.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлыг зохион байгуулж 7 байгууллагаас үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах, шинээр олгох, нэр солих хүсэлт ирүүлснийг шийдвэрлэлээ. Мөн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөлийн хурлыг хийж 2 өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэн хариу өглөө.

Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн албаны хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийж мэдээллийг 7 хоног бүр эрүүл мэндийн байгууллагуудаас авч нэгтгэн ЭМЯ –д хүргүүлэн ажиллалаа.

Корона вируст халдварын тандалтыг 6061 хүнд хийж, аймгийн хэмжээнд 1617 хүнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийн 3 удаа сул эерэг тохиолдол гарч Дорнод БОЭТ –д илгээж шинжлүүлэхэд сөрөг гарсан байна. Эрүүл мэндийн байгууллагууд гэрийн ажиглалтад 12 сард 4440 хүнийг авч тандалт судалгаа хийж ажилласан байна.

Голомтын ариутгал халдваргүйтгэлийг 16 автомашин, 11 объект нийт 4650 мк талбайд, Эрүүл мэндийн байгууллагын-33 баг, тусгай зөвшөөрөл бүхий-2 байгууллага ариутгал халдваргүйтгэлийг хийсэн байна.

26 төрлийн 158. 396.136 сая төгрөгийн Вакцин биобэлдмэлийг татан авч томуугийн дархлаажуулалтад эрсдэлт бүлэг буюу Цагдаагийн газар, Мэргэжилийн хяналтын газар, Хилийн цэрэг, хилийн нэвтрэх цэгт ажиллаж байгаа ачаа тээврийн жолооч нар нийт 6000 хүнийг хамруулсан хамралт 100 % байна.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ЭМГ, МХГ хамтарсан 2 баг Эрдэнэцагаан, Мөнххаан, Баяндэлгэр, Уулбаян, Түвшинширээ сумдад КОВИД-19 тохиолдлын удирдлагын тогтолцоо, эрсдэлийн үнэлгээ, халдварын эмнэлгийн бэлэн байдал, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр дэмжлэгт хяналтаар ажиллалаа.

Ковид-19 халдварын чиглэлээр орон нутгийн телевизэд -3 удаагийн ярилцлага мэдээлэл, ТВ шторк- 3 төрлийн 6 удаагийн давтамжтай иргэдэд хүргүүлсэн. Цахим хуудсанд 7 төрлийн мэдээллийг байршуулсан. Цахим сургалтыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 5 удаа, 8 сэдвээр хийж давхардсан тоогоор 150 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

Коронавируст халдварын эсрэг вакциныг нэвтрүүлэх бэлэн байдлыг хангах вакцинжуулах үйл ажиллагааны төлөвлөлтийг хийхэд шаардагдах хүний нөөцийн мэдээллийг гаргаж ХӨСҮТ-д хүргүүлэв.

Ковид 19 халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах чиглэлээр ЭМГ-ын даргын тушаал -2, зөвлөмж -5, чиглэл хүргүүлэх тухай -2 албан бичгийг тус тус хүргүүлсэн байна

"Хавдаргүй үрс" цахим сургалтад АНЭ, Өрхийн эрүүл мэндийн төвийн 17 эмч мэргэжилтэн, Олон улсын сувилахуйн эрдэм шинжилгээний "Коронавируст халдвар (covid-19) сувилагчийн манлайлал" цахим хуралд 15 ахлах сувилагч нарыг хамруулсан.

2020-2021 оны төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдсан 11 их эмчтэй гэрээ байгуулан ажилаж байна.

Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр:

Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Аймгийн Засаг даргын 2020 онд хамтран ажиллах гэрээний биелэлт гарган ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/608-р захирамжаар томилогдсон Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн эм эмнэлгийн хэрэгсэл, үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсхээс урьдчилан сэргийлэх ажлын хэсэг аймгийн төвийн болон захын хүс, барааны дэлгүүрүүдэд ажиллаж, үнийн судалгаа хийсэн.

Цагдаагийн газар: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу байгууллагын 2020 оны үйл ажиллагааны тайлангийн хурлыг зохион байгуулав.

Хуралд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, хууль, хяналтын тусгай чиг үүрэг бүхий байгууллагын удирдлагууд, цагдаагийн газрын Иргэний зөвлөл, Ахмадын зөвлөлийн дарга нар урилгаар оролцов. Хурлыг хорио цээрийн үеийн шаардлагад нийцүүлэн цагдаагийн газрын тасаг албадын төлөөллийг хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, хоорондын зайг чанд баримтлан зохион байгуулсан ба сумдын цагдаагийн тасаг, хэсгийн алба хаагчид цахимаар оролцов.

Алба хаагчдын ажлын хариуцлага сахилга, ёс зүйг дээшлүүлэх, зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний 2020 оны 4 дүгээр улирлын “Сахилга”-ын зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнөөр алба хаагчдын сахилга, ёс зүйн байдал, сахилгын зөрчил гарч байгаа шалтгаан нөхцөл, түүнийг арилгуулах арга зам, цаашид авах арга хэмжээ, сахилгын шийтгэлийн хор уршгийн талаар мэдээ, мэдээлэл өгч, алба хаагчдын санал хүсэлтийг сонсов. Зөвлөгөөнийг хорио цээрийн дэглэмийн үеийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулж, сумдын цагдаагийн хэсгийн алба хаагчид цахимаар оролцов.

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийг цагдаагийн ажил, эрх зүйч мэргэжлээр амжилттай төгсөж, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар “цагдаагийн дэслэгч” цол шагнагдан тус цагдаагийн газарт замын цагдаагийн зохицуулагч, хэсгийн байцаагч, жижүүрийн офицероор томилогдсон 3 албан хаагчийг хүлээн авч байгууллагын түүхэн замнал, үйл ажиллагаатай танилцууллаа. Мөн Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн “цагдаа” мэргэжил олгох сургалтад суралцаж амжилттай төгсөн, нөөцөд бүртгэгдсэн 2 албан хаагчийг эргүүлийн цагдаагаар томилж “цагдаагийн дэд ахлагч” цол олгов.

Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойг угтсан “Бүтээлч ажлын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, Эрүүгийн цагдаагийн албанаас улсын хэмжээнд зохион байгуулж буй “Үлгэрлэл манлайлал” аяны хүрээнд байгууллагын түүхэн замналыг алба хаагч, иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор цагдаагийн газрын үүдний 2 өрөөг засварлаж тохижуулан “Хүндэтгэл, мэдээллийн танхим”, “Иргэдийг хүлээн авах өрөө”-г шинээр байгуулав.

Аймгийн нутаг дэвсгэрт мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан”, байгуулах саналыг аймгийн ИТХ-ын ээлжит гуравдугаар хуралдаанаар хэлэлцүүлж, 100 хувийн саналаар сангийн дүрмийг батлаж, хяналт тавих зөвлөлийг байгуулав.

Улсын бүртгэлийн чиглэлээр: 12 дугаар сарын байдлаар дараах бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна.

Хуулийн этгээдийн бүртгэл: 12 дугаар сарын 28-ны байдлаар өссөн дүнгээр улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн тоо 1217. Үүнээс ХК-2, ХХК-646, төрийн бус байгууллага-120, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -1, орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -21, Төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар-137, нөхөрлөл-76, хоршоо-78, хадгаламж зээлийн хоршоо-4, сан-3, үйлдвэрчний эвлэлийн байгууллага-48, шашны байгууллага-13, хэвлэл мэдээллийн байгууллага-2 бүртгэгдээд байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-423, татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-64, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-214, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт - 480, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон -

653, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг 194 –г тус тус бүртгэн хурааж авсан байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл:

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ: Хүлээн авсан мэдүүлгийн тоо-153, анхны бүртгэл-33, өмчлөх эрх шилжих гэрээ-13, барьцааны гэрээ-78, бүртгэлд өөрчлөлт оруулах -4, лавлагаа хуулбар-7, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-47,

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ: Хүлээн авсан мэдүүлгийн тоо-108, анхны бүртгэл-11, өмчлөх эрх шилжих гэрээ-18, барьцааны гэрээ-55, бүртгэлд өөрчлөлт оруулах -14, лавлагаа хуулбар-1 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-43, нийт бичигдсэн лавлагааны тоо-1

Иргэний бүртгэл: 12 дугаар сарын байдлаар нийт 124 төрөлт, гэрлэлт 25, гэрлэлт цуцлалт 1, үрчлэлт 0, эцэг тогтоолт 2, овог нэр өөрчлөлт 5, нас баралт 32, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 0, үндэсний энгийн гадаад паспорт 0, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 85, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 463 тус тус бүртгэгдэж олгосон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр: Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар ханган ажилласнаар: 2020 онд Төлбөр, тэтгэлгийн 775 гүйцэтгэх баримт бичгийн 4,503,772,4 мянган төгрөгийн материал хүлээн авч, үүнээс: Төлбөрийн биелүүлбэл зохих 479 гүйцэтгэх баримт бичгийн 2,655,332,1 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулснаас 317 гүйцэтгэх баримт бичгийн 1,199,675,5 мянган төгрөгийн төлбөрийг биелүүлж, мөнгөн дүн 5 хувиар өссөн, улсын дундаж үзүүлэлтийн хувиас гүйцэтгэх баримт бичиг 15 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үүний үр дүнд төлбөр, тэтгэлгийн нийт 1,971,334,9 мянган төгрөгийг иргэн хуулийн этгээдэд төвлөрүүлэн олгосон байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шүүхийн шийдвэртэй 158,915,0 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр: 2020 онд хорих ялаас хугацааны өмнө суллагдсан 45, хорих ял оногдуулахгүй тэнссэн 100, тогтоолын биелэлт хойшлуулсан 4, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2, хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан 37, торгох ялтай 131, эрх хасах ялтай 34, нийтэд тустай ажил хийх ялтай 30 ялтан, этгээдүүд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль журмын дагуу явуулсан.

Сүхбаатар аймгийн прокурорын байгууллагаас энэ онд тус газрын хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтэд хийгдсэн 6 удаагийн хяналт, шалгалтаар зөрчилгүй дүгнэгдсэн, прокурорын шаардлага аваагүй, ялтан этгээдүүдэд холбогдох сургалт, хүмүүжлийн ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулан ажилласан.

Зөрчлийн тухай хуулиар оногдуулсан торгох шийтгэл, хохирол нөхөн төлбөр, эрүүгийн хуулиар оногдуулсан торгох ялын төлөлтийг барагдуулах ажлыг эрчимжүүлэн аймаг, орон нутгийн төсөвт хүү, торгуулийн орлого 2020 онд 81 сая төгрөгийн төлбөрийг төвлөрүүлсэн.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр: Хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу тус газар нь 2020 оны жилийн эцсийн байдлаар тоогоор хоригдолд 31 удаан хугацааны болон түр эргэлт уулзалт, 32 захидал, илгээмж зохих журмын дагуу зохион байгуулан ажилласан. Мөн хоригдогсдын ар гэрээс давхардсан тоогоор 257 хоригдогсдод эргэлт уулзалт, 168 захидал, илгээмж ирснийг тухай бүр нь хүлээн авч, зохих журмын дагуу ямар нэгэн зөрчил дутагдал гаргалгүй зохион байгуулсан.

Шүүхийн шинжилгээний алба: Албаны бие бүрэлдэхүүн аймгийн Цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнтэй хамтран хүний амь нас хохирсон хэргийн дуудлаганд 246 удаа хэргийн газрын үзлэгт оролцсон байна.

Криминалистикийн шинжээч нар нь хэргийн газрын үзлэгээр гутлын мөр 106 ширхэг, гарын мөр 78 ширхэг, тээврийн хэрэгслийн мөр 75 ширхэг, эвдлэгч багажийн мөр 11 ширхэг,

бусад ул мөр 182 ширхэг, бичил мөр 1 ширхэг, биологийн гаралтай ул мөр 2 ширхэг, ул мөр илрээгүй үзлэгийн тоо 118, нийт 455 ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авсан.

Криминалистикийн шинжээч нар гарын мөрний 20 шинжилгээ, мөр судлалын 50 шинжилгээ, бичиг баримтын 1 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан бөгөөд халуун мөрөөр нь 8 хэргийн эзэн холбогдогчийг, шинжилгээгээр нотолсон эзэнгүй 2 хэргийг олж тогтоосон байна. Тус албаны шинжээч эмч нар нь 4-р улирлын байдлаар хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 582 удаа хийснээс хүнд 18, хүндэвтэр 31, хөнгөн 180, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 191, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй 162 дүгнэлт гаргасан байна. Мөн бэлгийн маргаантай хэрэгт 42 дүгнэлт гарган ажилласан.

Гэмт хэргийн болон бусад шалтгаанаар нас барсан 75 хүнд шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийж дүгнэлт гаргаснаас гадна химийн 133 шинжилгээ хийсэн.

Аймгийн Цагдаагийн газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын лавлагаа авах албан бичгийн дагуу 325 хүний гарын хээний лавлагаа мэдээллийг албаны даргын зөвшөөрлөөр олгосон. Гэрэл зургийн чанарт онцгой анхаарч ажиллаж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд нийт 7960 кадр гэрэл зураг дарснаас хэргийн газрын үзлэгийн 4680, шинжилгээний 894, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 1691, бусад 695 кадр гэрэл зургийг боловсруулж, гэрэл зургийн үзүүлэлт хийж мөрдөгч нарт хүлээлгэн өгсөн байна.

Тав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд:

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр: Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулж АИТХ-р батлууллаа. Эдгээр баримт бичгийн төслийг боловсруулахдаа Мерит төслийн дэмжлэгээр удирдлагын академийн багш Ё.Батсүхээс зөвлөмж чиглэл авч ажиллалаа. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан бодлогын баримт бичиг боловсруулах талаарх зөвлөмж чиглэлийг аймгийн хэмжээний бүх сум агентлагт бичгээр хүргүүлснээс гадна бүх сумдын төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах чиг үүрэг бүхий албан хаагчдад бодлогын баримт бичиг боловсруулах арга зүйн зөвлөмж, сургалтыг цахимаар хийж, мэдээлэл өгч ажиллалаа. Уг хуулийн дагуу аймгийн хэмжээний нийт 13 сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд санал, дүгнэлт өгч баримт бичгийн боловсруулалтыг сайжруулахад анхаарч ажиллалаа.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаарх албан хаагчдын ойлголт мэдлэгийг сайжруулах зорилгоор Канадын ЗГ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй Мерит төсөлд санал тавьж Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль болон бодлогын баримт бичиг боловсруулах арга зүйн цахим сургалтад аймаг, сумын төлөвлөлтөд оролцдог нийт 60 гаруй албан хаагчидыг хамруулсан. Гол агуулга нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль болон бодлогын баримт бичиг боловсруулахдаа зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг хэрхэн тодорхойлох талаар мэдлэг олгоход чиглэгдсэн.

2020 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын талаарх тайлан мэдээ бэлтгэж холбогдох яамдууд болон бусад эрх бүхий байгууллагад хүргүүлээ.

Хөдөө аж ахуйн салбарт: Хүнс, хөдөө аж ахуйн газар: Засгийн Газрын 2019 оны 338 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын сайн малчин өрх, улсын хошой аварга малчин өрх шалгаруулах журам”-ын дагуу “Улсын аварга малчин өрх”-ийн шалгуур, болзлыг хангасан 11 малчин өрхийн материалыг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн ба эдгээрээс 5 малчин өрхийн материалыг ХХААХҮЯ-нд хүргүүлээд байна.

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийн судалгааг долоо хоног бүрийн 1, 4 дэх өдрүүдэд сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-ам, аймгийн шуурхай штабт хүргүүлсэн.

Азийн хөгжлийн банкны төсөл, ЖДҮГазар хамтран зохион байгуулсан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн бүтээгдэхүүнийг сурталчлах зорилготой monbiz.mn цахим катологи нэвтрүүлэх сургалтад жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн ХОХБТХэлтсийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

Зах зээл ба бэлчээр удирдлагын хөгжил төслийн хөрөнгөөр 12 суманд бог малын угаалгын ванн шинээр барих ажлыг “Том ноёд” ХХК гүйцэтгэсэн. Уг ажлыг улсын комисс

хангалтгүй гэж үзэж зардлын 20 хувьтай мөнгөн дүнд ирэх жил мал угаалгын ваннаа сайжруулах, засах үүрэг даалгавар өгч шийдвэрлэсэн.

Мөн уг төслийн хөрөнгөөр Түвшинширээ суманд өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих ажилд “ Гранд авгуш “ХХК гүйцэтгэсэн ба Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 229 дугаар “Зөвлөмж батлах тухай” тушаалын дагуу цахимаар хүлээн авсан бол 7 суманд гүний худаг шинээр барих ажлыг “Монгео физик” гүйцэтгэснийг, Дарьганга суманд хийгдсэн өвс тэжээлийн агуулахын засварын ажлыг тус тус улсын комисс ажиллаж, хүлээн авлаа.

2020-2021 онд аймгийн хэмжээнд 13 сумын 67 багт 7901 малчин өрхийн 4090.6 мянган толгой мал өвөлжиж байна.

Үүнээс:

- Сум орон нутагтаа 6242 малчин өрхийн 2912.4 мянган толгой мал
- Өөрийн аймгийн өөр сумын нутагт 1014 өрхийн 563.1 мянган толгой мал
- Хилийн зурваст 345 өрхийн 293.0 мянган мал
- Тусгай хамгаалалттай бүс нутагт 245 өрхийн 89.6 мянган мал
- Өөр аймгийн нутаг буюу Дорнод аймгийн Матад, Хөлөнбуйр, Булган Хэнтий аймгийн Баянхутаг, Биндэр сумдын нутагт **55 өрхийн 52.4** мянган мал
- Өөр аймгаас Дундговь, Багануур, Өвөрхангай, Төв, Баянхонгор, Архангай, Говь сүмбэр, Булган, Улаанбаатар хотоос **32 өрхийн 15,5 мянган** толгой мал тус тус өвөлжиж байна.

Өвөлжилтийн байдал: Баяндэлгэр, Асгат сумд цагаан зуд , бусад сумд цагаанаар зудархуу байна. Цасны байдлыг сумдаар авч үзвэл: Эрдэнэцагаан сум 14 см, Асгат, Түмэнцогт сум 13 см, Сүхбаатар, Асгат, Халзан сум 10-12 см, бусад нутгаар 6-9 см зузаан цастай байна.

Өвөлжилт хүндэрч буй сумдууд : Онгон, Наран, Баяндэлгэр, Асгат

Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс 2020 оны 12 дугаар сарын байдлаар гаргасан зудын эрсдэлийн үнэлгээнээс авч үзвэл:

Аймгийн нийт нутгийн 20.0 орчим хувь буюу Баяндэлгэр, Баруун-Урт сумдын ихэнх хэсгээр Эрдэнэцагаан, Асгат, Дарьганга, Сүхбаатар, Онгон, Уулбаян сумдын төв хэсгээр **нэн их**, эрсдэлтэй. 80 орчим хувь буюу Түмэнцогт, Мөнххаан, Уулбаян, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Онгон, Наран, Дарьганга, Асгат, Эрдэнэцагаан сумдын ихэнх хэсгээр **их** эрсдэлтэй гарсан.

Засгийн газрын 2020 оны 19-р тогтоолоор сум бүр аюулгүйн нөөцдөө 200 тн өвс, 50тн тэжээл буюу нийт 2600тн өвс 650 тн тэжээл, аймгийн аюулгүйн нөөцөд 900 тн өвс, 200 тн тэжээл бэлтгэх үүрэг өгөгдсөн. Үүнээс :

Аймгийн аюулгүйн нөөц		Сумын аюулгүйн нөөц		Малчдын түвшинд		Аймгийн хэмжээнд	
Өвс /тн/	Тэжээл /тн/	Өвс /тн/	Тэжээл /тн/	Өвс /тн/	Тэжээл /тн/	Өвс /тн/	Тэжээл /тн/
160		871	30	6400	250	7429	280

Мал эмнэлгийн газар: Коронавирусийн халдвар дотооддоо бүртгэгдэн хөл хорио тогтоосон үед АОК, аймгийн Засаг даргын шийдвэрийн дагуу 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл Мөнххаан, Түмэнцогт сумын авто замын пост, Баруун-Урт сумын Улаанбаатар чиглэлийн авто замын постод 24 цагаар эмч нарыг

ажиллуулан машины дугуй халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулан 1981 тээврийн хэрэгслийг зориулалтын бодисоор дугуйн халдваргүйтгэл хийсэн.

Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/601 дүгээр захирамжийг зөрчиж, согтууруулах ундаа худалдаалсан Баруун-Урт сумын “Өнө- Энхжин”, “Ар хошуут” ХХК-ийн согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/627 тоот захирамжаар хүчингүй болгох шийдвэр гарсан.

2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/693 дугаар захирамжаар 9 аж ахуй нэгжийн архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгаж, 1 аж ахуй нэгжид үйлчлэх эрх шинээр олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 113-р тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг батлан Сүхбаатар аймагт 500,0 зуун сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг олгосон. Үүний хүрээнд 2020 онд төсөл хүлээн авах зарыг олон нийтэд нээлттэй зарлаж, 30 аж ахуй нэгжийн 3,1 тэрбум төгрөгийн бизнес төслийг хүлээн авсан байна.

Орон нутагт төсөл сонгон шалгаруулах “Дэд хороо”-г аймгийн Засаг даргын А/351 тоот захирамжаар байгуулсан бөгөөд энэ жилийн хувьд “Жижиг дунд үйлдвэрийн газар”-ын төлөөллийн төслийн бодит байдал дээрх үнэлгээ, “Зээлийн мэдээллийн” сангийн программын үнэлгээ, Дэд хорооны үнэлгээний дундаж оноогоор төслийг үнэлсэн байна. Олгогдсон эх үүсвэрт дараах 5 аж ахуй нэгжийн бизнес төслийг сонгон шалгарсан. Үүнд:

1. Баруун-Урт сум 6-р баг – “Будар судар”-ХХК- аялал жуулчлалын чиглэлээр – 20.000.000
2. Наран сум 3-р баг” “Наран түмэн эсгий” ХХК – ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр- 100.000.000
3. Баруун-Урт сум 2-р баг “Чулуун дарь овоо” ХХК – арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр -56.000.000
4. Баруун-Урт сум 1-р баг “Бат гарьд эрдэс баяр” ХХК-зоорь, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр- 296.000.000
5. Баруун-Урт сум 5-р баг “Баян мөнх ундрах” хоршоо- Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр – 28.000.000. Сонгон шалгарсан аж ахуй нэгжүүд Жижиг дунд, үйлдвэрийн газартай гэрээ хийн санхүүжилтээ аваад байна.

Зам тээвэр, уул уурхайн чиглэлээр: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд аймгийн Засаг даргатай 2020 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт, 2021 оны хамтран ажиллах гэрээнд тусгах саналыг тус тус хүргүүлсэн.

Аймгийн төвийн авто вокзалыг гаднах зогсоолын засвар, Баруун-Урт сумын 3,4-р сургууль орчмын 4 байршилд аюулгүйн бүс байгуулах ажлуудад комисс ажиллан байнгын ашиглалтад оруулсан.

Эрчим хүчний чиглэлээр: Цаг агаарын тааламжгүй нөхцөл байдал, үзэгдэх орчны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Халзан сумын 35кВ-ын ЦДАШ-ын тулгуур №97, Мөнххаан сумын 15кВ-ын ЦДАШ-ын тулгуур № 287, Баруун-Урт Хойд-өндөр 1 10кВ-ын ЦДАШ тулгуур №39-г машин мөргөж ЦЭХ-ээр тасарсаныг засварлаж хэвийн ажиллагаанд оруулав.

Зургаа. Батлан хамгаалах салбарт

Батлах хамгаалахын төв архив, Тагнуулын ерөнхий газрын тусгай архив, Хил хамгаалах ерөнхий газрын хилийн цэргийн төв архивуудад цэргийн алба хаасан тухай архивын лавлагаа хүссэн 15 иргэний хүсэлтийг албан бичгээр гаргуулан олгосон.

Батлан хамгаалахын сайдын Сүхбаатар аймгийн Засаг даргатай хамтран ажилрах гэрээний биелэлтийг хангах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж өрхийн амьжиргааны төвшин буурсантай холбогдуулан 2020 оны I, II дугаар ээлжээр цэргийн албанд татагдаж Зэвсэгт хүчний болон Хилийн ангид алба хааж буй хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрт дэмжлэг үзүүлэх зорилгоор Баруун-Урт сумын 9 багаас тус бүр зорилтот бүлгийн нэг өрхийг сонгон авч 100000 төгрөгний хүнсний

өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, 50000 төгрөгний түлээ нүүрс, нийт тус бүр нэг өрхөд 150000 төгрөгний дэмжлэг үзүүлээ.

Зэвсэгт хүчний 338 дугаар ангид 2020 оны 2 дугаар ээлжээр цэргийн албанд татагдсан хугацаат цэргийн албан хаагчдад дархлаа дэмжих зорилгоор 3 төрлийн 600 ширхэг витамин, 200 ширхэг амны хаалт бээлий зэрэг зүйлсийг гардуулсан.

Монгол цэргийн нэгдсэн холбоо, Отгонтэнгэр Их Сургууль, аймаг, дүүргийн Цэргийн штаб хамтран зохион байгуулж буй “Эрхэмийн дээд монгол эр хүн” эсээ бичлэгийн цахим уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн 12-р ангийн сурагчдын дунд зарлаад байна.

Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил

Баруун-урт:

Хууль эрх зүйн чиглэлээр: -Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс үүдэн гарах хор уршигг бууруулах зорилгоор сумын хэмжээний хөтөлбөр боловсруулах ажил хийгдэж байна.

Тамгын газрын даргын тушаалаар улс төрийн болон үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажил хийгдэж байна. Мөн жилийн эцсийн эд хөрөнгийг тооллого явагдаж байна.

Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолын дагуу үнэлгээний баг гарч Тамгын газрын ажилтан, албан хаагчдын ажлыг үнэлж, дүгнэсэн.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг сумын ИТХ-д танилцуулж, батлуулсан.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр: Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал, хязгаарлалтын горимд шилжүүлсэн тул өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд эдийн засгийн болзошгүй эрсдэл, бизнесийн тогтворгүй байдал үүсч байгаатай холбогдуулан СХС-гийн зээл олголтыг Засаг даргын 2020 оны 3/283 тоот албан бичгийн дагуу зогсоогоод байна. Хугацаа хэтэрсэн 7 иргэний 4,8 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Иргэдтэй биечилэн уулзаж хугацаа хэтэрсэн өрийн мэдээг танилцуулсан. Мөн 2020 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн талаарх тайланг тэргүүлэгчдийн хуралд танилцуулсан. Хугацаа хэтэрсэн 53 иргэний 93,4 сая төгрөг төвлөрүүлсэн.

2019 оны цагдаагийн хяналтын камержуулалтын ажлын 15,0 сая төгрөгийг Цагдаагийн газар, 2019 оны А/218 тоот захирамжаар эрх шилжиж ирсэн хог зөөврийн авто машины үлдэгдэл санхүүжилтийг Мөнхөд Бадрах ХХКомпанид 100 хувь тус тус шилжүүлсэн.

2020 онд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 13 нэр төрлийн ажил, мөн урьд оны өрийг тусган 347,430.2 мянган төгрөгийн ажил сумын ИТХурлаар батлагдсан. Үүнд:

- ✓ Хог зөөврийн тусгай зориулалтын авто машины шинэчлэл засварын ажил
- ✓ Боловсролын салбарт дэмжлэг,
- ✓ Ногоон байгууламж,
- ✓ Хаягжуулалт,
- ✓ Гэрэлтүүлэг засвар үйлчилгээ,
- ✓ Төслийн оролцоо худаг гаргах,
- ✓ Зураг төсөв боловсруулах зэрэг ажлуудыг шууд худалдан авалтын журмаар зохион байгуулан ажилласан.
- ✓ Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт ажил харьцуулатын аргаар зохион байгуулж 26,326.1 мянган төгрөгөөр Хүрэлсоёмо ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажил 100 хувь гүйцэтгэсэн.

Сумын орон нутаг хөгжлийн сангаар сангаар хийгдсэн ажлын нийт гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна.

Аймгийн Засаг даргын А/125, А/255 дугаар захирамжаар нийт 812,700.0 мянган төгрөгийн ажил, улсын төсвөөр харъяа төсөвт байгууллагын 987,821.1 мянган төгрөгийн ажлуудыг тус тус 100% зарлан зохион байгуулсан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын Засаг даргын А/274 дүгээр захирамжийн дагуу 24 хүний бүрэлдэхүүнтэй 6 групп малчдаар явж тооллогын ажлыг зохион байгуулж байна. Хяналтын группүүд авч ирсэн 240-н малчин өрхийн малын тооны мэдээллийг мал тооллогын цахим санд шивэх ажил хийгдэж байна.

Байгаль орчин, дэд бүтэц, газар зохион байгуулалтын чиглэлээр: Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай хамтран хогийн нэгдсэн цэгийн талбайг цэгцлэх хогийг хуучин нүхэнд зөөвөрлөж, 7 хоногт 1 удаа түрэх ажлыг хийж байна.

Сумын Засаг даргын захирамжаар аж ахуй нэгж байгууллагуудад цас их хэмжээгээр орсон үед албан бичиг хүргүүлэн 50м хүртэлх нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлүүлэх ажлыг хийж гүйцэтгүүлэн хяналт тавьж ажиллаж байна.

Ковид 19 өвчнөөс урьчилан сэргийлэх зорилгоор Онцгой комиссын цахим хуралд 2 удаа хамрагдаж Баруун-Урт сумын хэмжээнд тусгаарлан ажиглах байр 8 буудлыг бэлтгэн бэлэн байдлыг хангаж 2 ажиглах байрыг Иргэдийн дотоод хөдөлгөөнд хяналт тавих ажлыг 13 цэгт төрийн байгууллагуудад хариуцуулан ажилласан.

Хүйтний улиралд хотын төвд мал их хэмжээгээр орж ирсэнтэй холбогдуулан багийн ажлын албатай хамтран бүх багийн малтай айл өрхүүдэд малаа хотын төвөөс гаргах хугацаатай албан мэдэгдэл хүргүүлж Сүхбаатар тохижилт үйлчилгээ, ОНӨААТҮГ-тай хамтран хотын төвд орж ирсэн эзэнгүй малыг хаших эзэн холбогдогчийг тогтоох арга хэмжээ авах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Сумын засаг дарга, Уртын гэгээ ОНӨААТҮГазрын дарга мэргэжилтэн нартай хамтран Дөрвөлж ОНӨААТҮГазартай хамтран цаашдын ажил үйлчилгээ гурвалсан гэрээг сунгах иргэдэд үйлчлэх үйлчилгээг сайжруулах Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын цаашдын хүндрэл бэрхшээлтэй асуудал, СӨХ-ын төлбөр хураамж зэрэг асуудлаар уулзалт ярилцлага хийлээ.

Сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын Засаг даргад танилцуулж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан.

Аймгийн төсөв хөрөнгөөр 2021 онд хийгдэх Баруун-Урт сумын 9 багт цамхагт гэрэлтүүлэг байршуулах ажлын тооцоо, зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Баяндэлгэр:

Сумын ИТХ-ын ээлжит 2 дугаар хуралдаан 12 дугаар сарын 18-ны өдөр хуралдлаа. Хурлаар: Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын 2020 оны хөгжлийн төлөвлөгөө, Сумын 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2021 оны төсөв ИТХ-ын хороодын бүрэлдэхүүн, ажиллах журам, 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2021 оны газар зохион байгуулалтын төлбөр зэргийг тус тус хэлэлцэн баталсан.

Төсөв санхүүгийн бодлогын хүрээнд: Орон нутгийн төсөвт тодотгол хийж, ИТХ-аар баталлаа. Мөн 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2021 оны төсвийн төслийг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулав. Төсвийн орлогын төлөвлөгөө 95,7 хувийн биелэлттэй байна.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэгт 908 хүн хамрагдсан. Гэрийн идэвхитэй эргэлт-24, Идэвхитэй хяналт- 76, Урьдчилан сэргийлэх үзлэгт- 613, Амбулаториор- 195, Больникод хэвтэн эмчлүүлсэн-26, хүүхэд-8, Алсын дуудлага- нийт 23, 0-5 насны хүүхдийн дуудлага 7 ирсэн дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн. Жирэмсний хяналтанд нийт 8 эх орсоноос эрт хяналтанд 7 эх орсон байна. АНЭ төрсөн эх -11 эх төрсөн.

COVID-19 халдвараас сэргийлэх зорилгоор хувийн автомашинтай болон хот хоорондын автобусаар зорчин ирж байгаа иргэдийн халууныг хэмжин тархвар судлалын асуумж бөглүүлэн ирсэн даруй гэрийн тусгаарлалтад аван хяналт тандалтыг хийж байна. Гэрийн тусгаарлалтад нийт 312 хүн орсон. Одоогийн байдлаар-154 хүн хянагдаж байна. Артерийн даралт ихтэй, сахартай, архаг хууч өвчтэй/ 25 хүнээс түргэвчилсэн оношлуулаар шинжилгээ хийхэд COVID-19 халдварын вирус илрээгүй.

Хүүхдийн цэцэрлэг: Теле хичээл 12 сарын 18-ныг хүртэл үргэлжилж багш нар эцэг эхчүүдтэй утас болон цахим орчинд байнга холбогдож зөвлөгөө зөвлөмжийг бэлтгэн хүргэж байна. Теле хичээл үзэлтийн хувь 83,4% байна. Туайн сард байгууллагын цахим хаягт нийт 63 зурган мэдээллийг оруулж 459 хүний хандалт, өөрсдийн бэлтгэсэн видео зөвлөмж 10 208 хүний хандалт, өөрийн бэлтгэсэн цахим хичээл 13 412 хүний хандалтыг авсан байна.

ЕБСургууль: 2020 оны 11 сарын 11-ээс хичээл сургалтын үйл ажиллагаа цахим хэлбэрээр явагдсан ба багш сурагчид теле хичээлийн тэмдэглэлийг хийж нээлттэй групп, чатаар холбогдон хамтран ажиллалаа.

Анги удирдсан багш нар сурагчдын теле хичээл үзэлтэд дэмжлэг үзүүлж зөвлөн туслахаас гадна хичээлийг бататган дасгал даалгаврыг боловсруулан цаасан болон цахим хэлбэрээр хүргэж ажиллалаа.

Сургалтын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнээр багш нар бусад багш нарын туршлага аргагүйгээс суралцаж нийт 632 хичээлийн тэмдэглэлийг хийж өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлж байна. 12 сарын 18 өдөр теле хичээл дуусч, нийт 6 долоо хоногийн теле хичээлийн үзэлт 78% хувьтай үзсэн байна.

Теле хичээлийн үеэр багш нар сурагчидтай цахим орчинд ажиллахын зэрэгцээ өөрсдийн мэдлэг боловсролоо дээшлүүлж, олон программ дээр ажиллаж сурсан ба цахим хичээл, зөвлөмжийг бэлтгэж, сурагчдадаа хүргэж ажиллалаа. Үүнд бага ангийн багш нар 218 ширхэг цахим хичээл, зөвлөмж, мэргэжлийн багш нар 334 цахим хичээл, зөвлөмжийг бэлтгэж хүргэсэн байна.

“Сэтгэлийн дэм” аяныг 11 сарны 27-оос 1 сарын хугацаатай өрнүүлсэн бөгөөд аянд ЕБС-ийн 88 багш ажилчид хамрагдан мөнгөн /1.300.000 төг/ болон эд материалыг өгч нэгдсэн. Аяны хүрээнд цугласан дэмжлэгээр өөрийн байгууллагын уурын зуухны галч нарт хөвөнтэй бээлий, чацаргана, сүү /235.000 төгрөг/, эмзэг бүлгийн сурагчдын ар гэрт /590.000 төгрөг/ хүнс, түлээний дэмжлэг дэмжлэг үзүүлсэн.

Соёл: Иргэдийн дархлааг дэмжих, урлаг соёлын идэвхийг нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үүднээс байгууллагын цахим хаягт “Ятгатай дуулъя” шууд дамжуулалтыг 2 удаа хүргэлээ. Номын фондын номын тооллого болон эд хөрөнгийн тооллого явагдаж байна.

Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Мал эмнэлгийн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2020 оны 10-р сарын 16-ны өдрийн А/561 тоот, Сумын Засаг даргын 2020 оны 10-р сарын 19-ний өдрийн А/120 тоот захирамжийн дагуу 854 өрхийн 293089 хонь, 192645 ямаа, 29028 үхэр, нийт 514762 толгой малыг 10 –р сарын 27-ны өдрөөс 11-р сарын 26-ныг хүртэл хугацаанд гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамруулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд малын эмч 9, жолооч 9, техникч 8, туслах ажилтан 17 иргэн ажилласан.

Аймгийн Засаг даргын 2020 оны 10 –р сарын 16-ны өдрийн А/561 тоот, Сумын Засаг даргын 2020 оны 10-р сарын 19-ний өдрийн А/120 тоот захирамжийн дагуу малын гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг сумын 836 өрхийн 96902 хурга хонинд хийсэн.

Байгаль орчны чиглэлээр: Иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх сарын аяны хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цас, мөсийг арилгаж, халтираа гулгаанаас хамгаалан ажиллаа. Уг арга хэмжээнд төрийн болон хувийн аж ахуй нэгжийн 11 байгууллага оролцож тайлан мэдээг ирүүлсэн.

Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулийн дагуу хаягдал ус гаргадаг 8 аж ахуй нэгжийн татварыг тооцож байгаль орчин уур амьсгалын санд төвлөрүүлсэн.

Дарьганга:

Сумын ИТХ-ын Ээлжит 3 дугаар хуралдаан 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж дараахь асуудлыг хэлэлцэв. Үүнд:

- Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хороодын ажиллах журам батлах тухай
- Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр төсөл хэлэлцэх тухай
- Сумын 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2021 оны төсвийн танилцуулга
- Сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай
- ОНӨААТҮГ-ын орон тоо бүтцийг батлах тухай

· Малын хөлөөс татвар авахтай холбогдуулан малчдаас саналыг авч, хэлэлцүүлэг зохион байгуулах асуудлыг шийдвэрлэж, жилийн эцсийн өрх хүн ам, хөдөө аж ахуйн тооллого явуулах ажлын хэсэгт хариуцуулан үүрэг чиглэл өгөх асуудлыг тус хурлаар хэлэлцэж шийдвэрлэв.

-Сонгуулийн үр дүнгээр бий болсон шинэ засаглал буюу сумын ИТХ-ын дарга, нарийн бичиг, сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга зэрэг орон тоонд шинээр томилгоо хийгдэж Авлигатай тэмцэх газарт ХАСУМ-ийг цахимаар хянуулж, цаасаар албан бичиг, албан тушаалын тодорхойлолтыг хүргүүлсэн.

- Сумын Засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг Тамгын газрын даргын үүргийг орлон гүйцэтгэгчээр ахлуулан сумын Засаг даргын захирамжаар томилж, мөрийн хөтөлбөрт тусгах саналыг баг, байгууллага, иргэд, төрийн албан хаагчдаас бичгээр авч, мөрийн хөтөлбөрийг боловсруулах, түүний хяналт шинжилгээ-үнэлгээний шалгуурыг тогтоох, мөрийн хөтөлбөрөөс 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

-Ковид-19 цар тахлын нөхцөлд худалдаа үйлчилгээний цэг салбарт гол нэрийн барааны үнийг нэмсэн байна гэсэн иргэдийн гомдол, саналын мөрөөр дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд: Сумын Засаг даргын 2020.12.23 ны өдрийн А/131дүгээр захирамжаар “Гол нэрийн барааны үнийн тогтворжилтод хяналт тавих” ажлын хэсгийг Тамгын газрын даргын үүргийг орлон гүйцэтгэгчээр ахлуулан 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллууллаа.

Сургалт сурталчилгааны чиглэлээр: “Эрх зүйн хөтөч”-ийн цахим сургалтад ЗДТГ-ын дотоод ажил, хууль эрх зүйн мэргэжилтэн, ЕБС-ийн нийгмийн ажилтан, АБУНТБ-ын багш нар 2 өдөр оролцлоо.

2020 оны 12 сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан “Боловсролын хуулийн төсөл”-ийн хэлэлцүүлэгт ЕБС, Хүүхдийн цэцэрлэгийн багш нар оролцож санал бодлоо хүргүүлсэн.

12 сарын 23, 24-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Үр дүнд суурилсан үнэлгээний зорилт” цахим сургалтад сургуулийн захирал, сургалтын менежерүүд хамрагдсан.

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар

ЕБС-ийн захиргаанаас цахим орчинд сурагчдаа идэвхжүүлэх, хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь санамж, зөвлөмж, уриалгыг хүргэв.

а/. Вирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж 37

б/. Хичээлээ сайн хийх уриалга 53

в/. Тайлан мэдээ 13

г/. Видео, шторк 42

-Хөгжмийн багш Ч.Батзориг “**Бид дуучид**”, дүрслэх урлагийн багш Б.Энхмаа “**Шинэ жилийн гацуураа бүтээцгээ**” цахим уралдааныг зохион байгуулж, дүнгээ гаргалаа. Дээрх уралдаанд нийт 23 хүүхэд оролцсон.

-Халдварын тархалттай цаг үед багш, ажиллагсдадаа нэг удаагийн тусламж, дэмжлэгийг сургуулийн захиргаанаас хүргэсэн. **Үүнд: нэг хүнд**

- Аарц 1кг
- Нэгж 7000₮
- Гэр интернет 25000₮ нийт 1 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэсэн байна.

Багш нарын мэдээлэл харилцаа технологийн чадамж, хэрэглээ, ашиглалтыг тандах зорилгоор googleform программ ашиглан судалгаа авч, дүгнэлтийг гаргасан. Нийт 30 багш хамрагдахаас 23 багш буюу нийт багш нарын 76.6% хамрагдсан.

Цэцэрлэг: Ковидтэй холбогдуулан байгууллагын халдваргүйжүүлэлтийн нөхцөл байдалд 2,400,000 мянган төгрөг зарцуулан хлорын шохой, кварцын гэрэл, автомакс, болон ажилчдыг витаминжүүлэх ажлын хүрээнд нэг хүнд 6 төрлийн 44,950 төгрөгний зүйлийг өгч дархлааг дэмжлээ.

Мөн хүнсний бүтээгдэхүүний багцыг өрхийн орлогогүй болон амьжиргааны түвшин доогуур айлын 40 хүүхдэд хүргэж, сумын хамтарсан багтай хамтарч 18 хүүхдэд хүнс болон түлээ нүүрсний тусламж дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: 12-р сарын 8-19 нийг хүртэл 10 хоног “Томуугийн эсрэг дархлаажуулалт”-ыг албан байгууллага, ААН-ийн ажилчид болон 3-15 насны хүүхдүүдийг вакцинжуулсан. Үүнд: Төрийн албан хаагч-21, Албан байгууллага-145, Худалдаа үйлчилгээ-27, 3-15 нас -236, Архаг хууц өвчтөн-19, 65-аас дээш-16, Ачаа тээврийн жолооч-6 хамрагдсан.

Гэрээр 65-аас дээш насны ахмад болон 3-аас дээш насны хүүхэд нийт 178 хүнийг гэрээр очин дархлаажуулж зөвөлгөө өгсөн.

Хүнсний дэлгүүр, үсчин гоо сайханы газраар явж Аймгийн эрүүл мэндийн газраас ирүүлсэн албан тоотыг КОВИД-19 халдварын үеийн зөвлөмжийг танилцуулж хүргэсэн. Олон нийтийн сүлжээгээр 147 мэдээлэл, зөвлөмжийг түгээж 5266 хүн үзсэн байна.

Хөдөө аж ахуйн болон төв суурингийн өвөлжилтийн талаар

Төв суурингийн нэгдсэн халаалтын зуухны нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар аймгийн удирдлагад танилцуулаад байна.

Хөдөөгийн малчдаар өрх хүн ам, хөдөө аж ахуйн тооллогын комисс ажиллаж байх хугацаандаа мэдээлэл өгч, малчдын ахуй байдалтай газар дээр нь танилцаж, одоогоор зутарсан, өвөлжилт хүнд байгаа малчин байхгүй байна.

Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн чиглэлээр: Нийгмийн даатгалын байцаагч нь Малчин нөхөн төлбөрөөр тэтгэвэр тогтоолгох ажлыг идэвхтэй зохион байгуулж аймгийн хэмжээнд хамгийн олон буюу 59 малчныг нөхөн төлбөрт хамруулж 124 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн төлөвлөгөөг 241 %-аар биелүүлсэн

"FOOD BANK" аяны хүрээнд 12 өрхөд 500000 төгрөгний хүнс, болон түлээ нүүрсний тусламж олгосон.

Мөнххаан:

Аймгийн Засаг даргын 2020 оны А/620 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу сумын 2020 оны үйл ажиллагааны тайланг 12 үзүүлэлтээр гаргаж, ХШҮнэлгээ хийн аймгийн ХШҮДАХ-т хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Аймгийн Засаг даргын Ковидтой холбоотой 9 захирамжийн 47 заалт, 2 албан даалгаврын 10 заалтын ын биелэлтийг 4 дэх өдөр хяналт шинжилгээ дотоод аудитын хэлтэст хүргүүлж ажиллаж байна.

Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багцын сургалтад 1 төрийн албан хаагч, ахисан түвшний мэргэшүүлэх сургалтад 1 төрийн албан хаагч, ахисан түвшний жөндөрийн дүн шинжилгээ цахим сургалтад 2 төрийн албан хаагч, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлага зохион байгуулалтын тухай хууль хэрэгжилт бодлогын уялдаа тухай модуль цахим сургалтад 3, орчны бохирдлын эх үүсвэр хог хаягдлын тоо бүртгэлийн мэдээллийн сангийн цахим сургалтад 1, Мал эмнэлгийн гарал үүслийн цахим гэрчилгээ олгох сургалтад 1 төрийн албан хаагч нийт 7 төрийн албан хаагч тус тус хамрагдсан.

Төсөвт 5 байгууллагад энэ онд нийт ирсэн 154 өргөдлөөс шийдвэрлэсэн 148, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 4, хугацаа болоогүй 2. Үүнээс бичгээр 79 , цахимаар 8 , утсаар 25, амаар буюу биечлэн уулзсан 42 байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн оператороор 14 төрлийн 229 лавлагааг иргэд авч үйлчлүүлж төлбөрийн 260700 төгрөгийг дансанд төвлөрүүлсэн.

2020 оны жилийн эцсийн тоогоор хүн ам 4923 тоологдсоноос эм 2413, эр 2510 байна.

Санхүү төрийн сан: ЗДТГ нь хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө хөдөлмөрийн гэрээг үндэслэн дүгнэж 7,5 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг 24 төрийн албан хаагчдад олгосон.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө 139605,0 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 152158,2 мянган төгрөг буюу 108 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 151,161.9 төгрөгөөр орон нутгийн төсвийн хөрөнгөөр 151,488.2 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлуулан хуваарийн дагуу санхүүжүүлж ажилласан. ЖГҮнэлгээний хувь 2019 онд хувьтай үнэлэгдэж улсад 174 байранд орж байсан бол 2020 онд 84 хувьтай үнэлэгдэж улсад 11-р байранд орж 50 хувийн урамшуулал авахаар болсон.

Хууль эрх зүйн хүрээнд: 2020 онд Цагдаагийн хэсэг нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 57, зөрчлийн шинжтэй 77, хялбаршуулсан журмаар 1474-н зөрчил илрүүлж шийдвэрлэж нийт 1609 тооны өргөдөл, гомдол мэдээлэл, зөрчлийг хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 57 тооны өргөдөл гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсанаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн-34, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай 23-ийг тус тус шалгаж шийдвэрлэсэн байна. Өнгөрсөн онд гэмт хэргийн шинжтэй 75-н тооны өргөдөл, гомдол хүлээн авч байсан бол энэ онд 57-г хүлээн авсан нь урьд оноос 24% буурсан байна. Сумын хэмжээнд урьд онд 46-н гэмт хэрэг гарч байсан бол энэ онд 34 гэмт хэрэг гарсан нь урьд оноос 12 хэргээр буюу 26% буурсан үзүүлэлттэй байна. Зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт 55.3% өссөн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг урьд онд 7 байсан бол энэ онд согтуугаар гэмт хэрэг 15 үйлдэгдэж 8 буюу 46.6% өссөн байна. Бүлгээр үйлдэгдсэн гэмт хэрэг урьд онд 6 үйлдэгдэж байсан бол энэ онд 1 үйлдэгдсэн байна.

Нийгмийн бодлогын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: 2020 оны жилийн эцсийн байдлаар сумын хэмжээнд бага боловсролд суралцвал зохих 525 хүүхэд байгаагаас 524 сурагч суралцаж хамран сургалт 99.8%, суурь боловсролд суралцвал зохих 320 хүүхэд сурагч байгаагаас 310 сурагч, насан туршийн боловсролд 9 хүүхэд, нийт 319 сурагч суралцаж хамран сургалт 99.6%-тай байна. ЗАН-ууд болон сургалтын менежерүүд, нийгмийн ажилтан нягтлан бодогч нарын цахим орчинд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж нийт 8 гэр интернет төхөөрөмжөөр хангаж сургуулийн орчин дахь утасгүй интернетийн эх үүсвэрээр 100% хангасан. ЕБС-ийн сайн үйлсийн аяныг байгууллага дээрээ зохион байгуулж сумын зорилтот 20 өрхөд 70,0 мян төгрөгийн багцын хүнсний бүтээгдхүүнийг нийт 1400000 төгрөгний тусламж дэмжлэг үзүүлсэн.

Багш ажилчид цахим хэлбэрээр хэрхэн ажиллах, арга хэлбэрийг чиглүүлж “Цахим орчинд ажиллах журам”-ыг боловсруулан баталсан. Энэ журмаар, цахим үйл ажиллагааг, “1.Багшийн хөгжил, бүтээлч үйл ажиллагаа. 2. Теле хичээлийн зохион байгуулалт, явц, үр дүн. 3. Цахим хуудаснуудын идэвхитэй үйл ажиллагаа. 4. Цахим мэдээлэл боловсруулах, түгээх. 5. Хяналт, үнэлгээ, дүгнэлт, засан сайжруулах” гэсэн 5 чиглэлээр төлөвлөж үр дүнг тооцож хэрэгжүүлсэн. Цэцэрлэгийн 10 бүлгийн дотоод группт хүүхдийн сурах орчны талаар мэдээлэл боловсруулан эцэг эхэд хүргэж, түүнийг судалсны үндсэн дээр “Хүн бүр хүүхдийнхээ төлөө” 7 хоногийн аян зарлан хэрэгжүүлсэн. ГБХЗХГ-аас зохион явуулсан уралдаанд Д.Ариунмөнх эрхлэгчтэй цэцэрлэгийн хамт олон БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ “ШИЛДЭГ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ”-өөр “ДЭД БАЙР”-нд шалгарлаа. ЗДТГ, Хүүхдийн цэцэрлэг ажлын байран дээр хүүхдийн өрөөг бий болгосон.

Соёл урлагийн чиглэлээр: Соёл урлагийн арга хэмжээ Ковид -19 цар тахлын улмаас зохион байгуулагдаагүй. Соёлын байгууллагаас иргэдийг Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх уриалга , зөвлөмж, сэрэмжлүүлэгийг мөн соён гэгээрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж цахим болон уэль техник ашиглан мэдээллийг хүргэн ажилласан. Уриалга зөвлөмж 25 удаа , шторк 5 төрлөөр цахим хэлбэрээр сумын цахим сайт, фесбүүк хаягт байршуулсан. 2020 онд хөдөөгийн 4 баг сумын төвийн 1 багт явуулын үйлчилгээг 10 удаа зохион байгуулж 412 уншигч үйлчлүүлэгчдэд 1500 гаруй номоор үйлчилж соён гэгээрүүлэх ажил 4 удаа зохион байгуулсан.

Халамжийн чиглэлээр: 2019 онд ажилгүйдлийн түвшин 28% байсан бол 2020 онд 21% болж буурсан үзүүлэлттэй байна. 2020 онд Шинээр бий болсон ажлын байрыг 56, ажилд зуучлагдсан иргэдийн тоо 51 байна. ХЭБҮ- авагч 88 өрхийн 399 иргэнд 11 сарын байдлаар нийт 90,960,000 төгрөг “Буян арвижих –Их уул” ХХК-ны дансанд шилжүүлээд байна. “**FOOD BANK**” аян Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай томуу болон коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх хорио цээрийн дэглэмийн үед хүнс тэжээлийн дутагдлаас сэргийлэх, дархлааг нэмэгдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллаг, аж ахуй нэгж, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх зорилготой “FOOD BANK” зорилтот бүлгийн иргэдэд дэмжлэг, тусламж үзүүлэх лангууг “Их уул” дэлгүүрт байрлуулан 2020.12.18-11.30 хүртэлх хугацаанд уриалга гарган ажилласан. Нийт 11 Аж ахуй нэгж, иргэд идэвхтэй оролцож 192 төрлийн 979,600 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн цугларсан. Зорилтот 30 өрхөөс 5 өрхийн 25 иргэнд 276000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн олгоод байна. Амьжиргааг дэмжих зөвлөл 17 удаа хуралдаж 141 иргэний хүсэлтийг хүлээн авч 139 иргэний асуудлыг шийдвэрлэсэн. 2 иргэний асуудлыг буцаасан байна. Шинээр асаргаа 6 иргэнд, Асаргаа сунгах 18 иргэний хүсэлтийг хүлээн авч 18 иргэнд асаргаа тогтоосон. Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжид 1 иргэний хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор хөдөөгийн 3 багт мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн энэ онд нийт 64 иргэн шинээр тэтгэвэр тогтоолгосоны 21 нь малчнаар орсон байна. Нөхөн тооцох хуулиар 48 иргэн хамрагдсанаас 21 нь малчнаар тэтгэвэрт ороод байна. Энэ онд хэрэгжиж байгаа 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн НДШ-ийн 50%-г төрөөс төлөх даатгалд 46 эх хамрагдан даатгуулж байна. 2020 онд Эрүүл мэнд 1384 хамрагдахаас 684 хамрагдаж 72.0% хамрагдаад байна. Сайн дурын даатгалд 435 хамрагдахаас 298 хамрагдан 68,0% -тай байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Сар бүр эмийг цахимаар хөнгөлөлттэй олгож байна. 2020 онд нийт 2837 хүнд 33436,0 мян төгрөгийн эмийн хөнгөлөлт үзүүлсэн. ЭЭСангийн хяналтын зөвлөл үйл ажиллагаанд 2 удаа хяналт үнэлгээ хийсэн. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт - 98% байна. ЭМТ-ын бэлэн байдлыг хангах үүднээс яаралтай тусламжийн болон ариутгалын тоног төхөөрөмж ЭМТөвийн төсөв болон хандиваар 9,549,000 төгрөгөөр авч үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Үүнд: /автоклав-2, хүчилтөрөгч өтгөрүүлэгч-2, дуслын памп-1, утлагын аппарат-2, халуун хэмжигч-1, автомат автомакс-1, автомакс-2/

Мал эмнэлэгийн болон Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр нийт 441354 толгой мал тоологдсон. Үүнээс: тэмээ 574, адуу 37618, үхэр 31672, хонь 224384, ямаа 147100 шинээр мянгэт малчин 19 төрөн гарч сумын хэмжээнд 79 мянгат малчин байна. Малчин өрх -904, малтай өрх 1099 боллоо.

2020 онд 8 төрлийн /шөвөг яр, галзуу, сахуу, дуут хавдар, цусан халдварт, ДХХ энробактериоз, боом, томуу/ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 172,7 мянган мал сүргийг сумын халдварт өвчний гаралт тархалтын судалгаанд үндэслэн хамруулахаас 172,5 мянган мал сүргийг хамруулж 99,9 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж дүн мэдээг нэгтгэн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн. 2020 онд сэг зэм устгал халдваргүйтгэлийн ажлыг малчин, мал бүхий өрхийн 417 хашаа хорооны 81,4 мянган м.кв талбай, 47 ш худаг уст цэгтийн 6,6 мянган м.кв талбай, мал, амьтны тоног хэрэгсэл 420 ширхэг, 9 ширхэг зоорь агуулах, бүтээгдэхүүн хадгалах цэг, тэжээлийн агуулахын 18,2 мянган м.кв талбай, устгалын цэгийн 159.0 мянган м,кв талбай, бэлчээрийн 126.8 мянган м,кв талбай, нийт 388.8 мянган м.кв талбайд заавар арга зүйн дагуу халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр: Сумын нутаг дэвсгэрт бүртгэлтэй 67 цэг тэмдэгтийн тооллогын ажлыг хийж гүйцэтгэх ажлын хэсгийн удирдамжийг батлуулан төлөвлөгөө маршрутыг гарган тооллогын ажлыг хийсэн. Нийт 67 цэгээс тооллого хийхэд 2 цэг устаж гэмтсэн байсныг тогтоосон. Энэ онд WEB буюу газрын цахим программ системд газрын хэмжээ талбай өөрчлөх болон гэр бүлийн 1 гишүүнд газар өмчлөлийн эрх шилжүүлэх, мөн худалдах болон бэлэглэх гэрээгээр нийт 15 иргэний өргөдлийг бүртгэж зөрчлийг арилгасан. Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар хуралдааны тэмдэглэл болон, ГХБХБГазрын даргын 2020.04.17-ны 1/138 тоот албан бичгийг үндэслэн энэ онд иргэдэд газар өмчлүүлээгүй.

Түвшинширээ:

Холбогдох хууль, улс, аймгийн Онцгой комиссын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын дагуу сумын Засаг даргын А/68, А/70, А/71, А/74, А/81, А/83 дугаар захирамжуудыг гарган сум орон нутагтаа дагаж мөрдөн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020.12.15-ны "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авах зарим арга хэмжээний тухай" А/74 дугаар захирамж гаргаж байгууллага аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Аж ахуйн нэгжүүдэд Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны 1/142 тоот албан бичгээр худалдаа үйлчилгээний байгууллагын дарга эрхлэгч нарт "Үйлчилгээний байгууллагын хэвийн нөхцөлд ажиллахад мөрдөх журам"-ыг хүргүүлж, уг заавар журмыг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болголоо. Албан байгууллагууд иргэдэд зай барьж үйлчлүүлэх боломжийг хангаж байгууллагын коридортоо 2 метрт зай барь санамжийг байршуулаад байна.

Малын тоо толгойн татварын тухай хууль хэрэгжиж эхлэх гэж байгаатай холбогдуулан жилийн эцсийн мал тооллогын ажилтай хамтатган хуулийн талаарх мэдээлэл олгож, брошур тарааж, малчдаас малын тоо толгойн татварын талаар санал асуулга авч байна.

Хөрөнгө оруулалт, дэд бүтэц, байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Аймгийн засаг даргын 2020 оны А/589 дүгээр захирамж, сумын Засаг даргын А/76 дугаар захирамжаар 2020 оны жилийн өрх, хүн ам, хөдөө аж ахуйн тооллогыг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 28-ны хооронд зохион байгуулан ажиллаж байна. Тооллогын ажлыг 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн ажлын 8 хэсэгт багийн засаг дарга нар, багийн иргэд нийтийн хурлын дарга, төрийн захиргааны албан хаагч, малын эмч, хүний эмч, жолооч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр хэсэг бүрт 5-6 албан хаагчийг томилон ажиллуулсан. Ажлын хэсэг бүр Түвшиншрээ сумын нутаг дэвсгэрт байгаа бүх малтай өрх болон нийт өрхөөр орж тооллогын ажлыг хийж гүйцэтгэлээ. Тооллогын явцад цаг агаарын болон бусад сөрөг хүчин зүйл илрээгүй. Хяналт тавих аймгийн комиссоор Сүхбаатар аймгийн Байгаль орчны газрын дарга Х.Төмөрхуяг суманд ажиллалаа.

Тооллогын явцад сумын Засаг дарга болон Засаг даргын орлогч хяналт тавьж ажилласан.

Хөдөөгийн 4 багийн 421 хот айлын байршлын судалгааг гаргаж Өлзийт багт 2 ажлын хэсэг, Үнэгд болон Дэлгэрхаан багт 3 ажлын хэсэг, отрын нутагт 1, Өгөөмөр багийн 2 ажлын хэсэг гарган ажлын хэсэг тус бүрт 1, хяналтын хэсэг 1, нийт 9 автомашин ажилласан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: "COVID-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор бүх нийтийн хорио цээрийн дэглэм тогтоосон энэ үед нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг томуу болон коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дархлааг нэмэгдүүлэх, тэдэнд тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор "FOOD BANK" аяныг зохион байгуулсан. Аяны арга хэмжээнд сумын хэмжээнд 4 албан байгууллага, 6 аж ахуйн нэгж, 57 өрх иргэн оролцож нийт 2,840,000 төгрөгийн өртөгтэй түлээ нүүрс, ахуйн болон ариун цэврийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүнийг 41 өрхөд тусламж дэмжлэг үзүүлсэн. 12 дугаар сард ЕБС, хүүхдийн цэцэрлгүүд сумын зорилтот бүлгийн хүүхдүүдэд хүнс, түлээ нүүрсний дэмжлэг үзүүлсэн. 12 дугаар сарын 24-нд сумын Хамтарсан багийн зүгээс эрсдэлт нөхцөлд байгаа 1 хүүхдэд хүнс/100000 төгрөг-ний дэмжлэг үзүүллээ.

Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр

Боловсролын чиглэлээр: ЕБС:2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 11дүгээр сарын 11 хүртэл 58 хоног танхимаар хичээллэж БШУ-ны сайдын 2020 оны А/165 дугаар тушаалын дагуу 12 дугаар сарын 18 хүртэл сургалтын үйл ажиллагаа теле болон цахим хэлбэрээр зохион байгуулагдаж оныг дуусгаж байна. Энэ хугацаанд сургуулийн бүх багш, ажилтнуудыг удирдлага арга зүйгээр ханган хөл хорионы үеийн ажлын зохион байгуулалт, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, улирлын ажлын төлөвлөгөө болон цахимаар ажиллах үеийн төлөвлөгөөг гарган биелэлтэд анхаарч ажиллалаа.

Ковид- 19 цар тахлаас болж сургалтын үйл ажил цахимд шилжсэнээр 6 долоо хоног ТЕЛЕ хичээл үзлээ. Теле хичээлийн үзэлтийн хувь 7 хоног тутмаар өсч 93 хувь болсон байна. Суралцагчид маань ТЕЛЕ хичээлээ сайн үзэж багш нартайгаа эргэх холбоотой ажиллаж байна. Теле хичээл үзэх боломжгүй сурагчидтай утсаар ярих, дасгал даалгавар хүргүүлэх ажлыг хийж байна. Багш нарын мэдээлэл харилцаа технологийн мэдлэг сайжирч rowtoon, powerpoint, bandicam, google form зэрэг программуудыг шинээр сурах, бие биендээ зааж өгснөөр бататгал хичээл-58 ,цахим сорилго -74 боловсруулан сургууль, ангийн группээр дамжуулан суралцагчдад хүргэж байна. Мөн сургууль сумын хуудсаар хүүхдийн хамгаалал, аюулгүй байх, халдвар хамгааллын дэглэмээ барих, теле хичээлийн тухай багш бүр өдөр болгон санамж зөвлөгөө зөвлөмжийг оруулж байлаа.

Байгалийн ухааны хичээлээр " Суралцахуйг төлөвлөхийн өмнө" онлайн 5 хоногийн цуврал сургалтанд сургалтын менежер,бага ангийн багш нар хамрагдаж эхэллээ. Сургалтын төлбөрийг "БАГШИЙН ХӨГЖИЛ-СУРАГЧИЙН АМЖИЛТ" төслөөс санхүүжүүлэв. Үнэлгээний онлайн сургалтад захирал сургалтын менежерүүд 12-сарын 23,24-нд хамрагдсан.

Эцэг эхийн дунд “Үлгэрч аав ээж” уралдааныг зарлаж дүгнэлээ. Энэ уралдаанд 30 гаруй эцэг эх оролцож 260 үлгэр уншин өгчээ. Шагналыг СТХ –Багшийн хөгжил Сурагчийн амжилт төслөөс 140000 төгрөг гаргаж санхүүжүүлэв. “Янзаган хүрээг хайрлаарай ” видео хичээлийн уралдаанд 2 хичээлийг хийж явууллаа. Аймгийн ИТХ аас зарласан “Цагаан зээрээ хайрлан хамгаалъя” эссээ, зургийн уралдаанд 7 хүүхэд оролцлоо. Аймгийн БСУГ аас зохион байгуулж байгаа “Цахим орчин – Хөгжлийн талбар” хуудсанд 14 багш сургалтын менежер -1, захирал нар өөрийн туршлагаа байршуулан сурталчиллаа.

Сумын ОК-т хамт олноо уриалан санаачлага гарган хамтын сангаасаа 1сая төгрөгийг хандивлалаа. МУЗГ-ын 2020 оны 11-р сарын 23-ны өдрийн 188 дугаар тогтоолоор үдийн цай, дотуур байр хүүхдийн хоол хүнсэнд зарцуулахаар нөөцөлж, төлбөрийг нь бүрэн барагдуулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг анги удирдсан багш, нийгмийн ажилтны гаргасан судалгааг үндэслэн сургуулийн насны хүүхэдтэй хүнсний дэмжлэг үзүүлэх шаардлагатай зорилтот бүлгийн 15 өрхийн 40 хүүхэд тус бүрт нь дунджаар 110.000 гаруй нийт 4421480 төгрөгний бүтээгдэхүүнийг халдвар хамгааллын дэглэм баримтлан нийгмийн ажилтан, нярав, ня-бо нараар түгээлт хийлгэлээ.

КОВИД-19 цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг сайтар бариулж санамж зөвлөмжийг байнга өгч байлаа. Багш, ажилтнуудын хөдөлмөр хамгааллын асуудлыг шийдвэрлэхийн тулд нүүрний хаалт хүн бүрт байгууллагаас авч өгсөн ба 500 ш маск, 10л гар ариутгагч, 300 ш жавелин, 20 кг хлорын шохой зэргийг нөөцөнд бэлтгээд байна. Хатуу хөл хорионы үед постод гарах багш ажилтнуудад гэр бариулж, байгууллагаас түлээ нүүрс мод болон маск, ариутгалын бодисоор ханган ажиллалаа.

#Хүүхдийг Ивээх Сан-гийн боловсролын мэргэжилтнүүдийн зөвлөгөөг хүргэхийн зэрэгцээ 33 багш нартаа байгууллагын шуудан холбооны зардлаас 165.0 төгрөг зарцуулж тус бүрийн утсанд нь 5000 нэгж хийж өглөө. Холбогдохгүй байгаа хүүхдүүдтэй холбогдож тэдний нөхцөл байдалтай сайтар танилцаж боломжит арга хэмжээг авч ажиллахыг нийт багш нартаа уриаллаа. Танхимын сургалт түр хугацаагаар зогсож багш нар маань гэрээсээ онлайнаар ажиллах болсон өнөө цагт тэдний зөөврийн компьютерийн ажиллагаа түргэн шуурхай байх шаардлагатай байгааг үндэслэн байгууллагынхаа төсвийн хичээл үйлдвэрлэлийн зардлаас 1.204.833 төгрөгийг зарцуулж ӨҮ ЭЛ /ОЛ/ ХХК-аас баталгаатай 1 жилийн эрхтэй вирусны эсрэг программыг худалдан авч багш нарынхаа онлайн ажилд нь дэмжлэг үзүүллээ.

Номын санч суралцагчид, багш, ажилтан нартаа гэрээр ном олгоход нийт 106 хүн хамрагдсан байна. 42 өгүүллэг, 52 үлгэр, туужуудыг байнга сум, сургуулийн цахим хуудсанд

оруулж уншуулах ажлыг зохион байгууллаа. Орой болгон “Үлгэрийн цаг” гарчигтайгаар унших үлгэр болон сонсох үлгэрийг мөн цахим хуудсанд оруулсан.

Хүүхдийн цэцэрлэг: Коронавирус халдварт цар тахлын үед хорио цээрийн дэглэмийг чанд сахиж 8 бүлгийн багш нар теле хичээлийн үзэлтийн тандалт судалгааг тогтмол хийж дотоод группээрээ ажиллаа. Үүнд теле хичээл үзсэн 196, үзэж чадаагүй 36 хүүхэд хамрагдалт 84,1%-тай байлаа. Мөн зөвлөгөө 8370, зөвлөмж 8120-ийг группээр тавьж хандалт 2149 байлаа.

Хүүхэд хамгааллын чиглэлээр: Байгууллагын хүүхэд хамгаалалын баг зорилтот өрхийг 31 хүүхэдтэй байнга холбоотой байж тэдэнд тусламж дэмжлэгийг тогтмол үзүүлж ирлээ. Үүнд залуу багш нарын холбоо 110,000 мянган төгрөг цуглуулж 2 өрхийн хүүхдэд түлээ нүүрс, хүнсний материал, Foodbank аянд нэгдэж 353,700, нэг гэр бүлээс 40500 төгрөг нийт 504,200 төгрөгний хүнс болон ахуйн хэрэглээний зүйлийг 16 хүүхдүүдэд хүлээлгэн өгсөн.

БШУЯамны сайдын А/162 тоот тушаалын дагуу хүүхдийн хоол хүнсний үлдэгдэл 1,957,300 төгрөгний хүнсний материалыг 25 хүүхдэд өгсөн. Хүүхэд хамгаалалын багаас аян өрнүүлж багш, ажилчид 140,000 мянган төгрөг, хүнс, хувцас цуглуулж амьдрал хүнд эцэг эх хараа хяналт сул 1 өрхийн 2 хүүхдэд тусламж дэмжлэг тогтмол үзүүлж байна. Байгууллагаас 2 өрхөд хагас, хагас тонн нүүрсний дэмжлэг үзүүллээ.

Хараа хяналт сул 3 өрхийн хүүхдийн эцэг эх, албан байгууллагатай нь тохиролцож ажлын цагийн зохицуулалт хийлгүүлж хэвшин хэвийн ажиллаж байна.

0-12 насны хүүхэдтэй багш ажилчидаа гэрээр нь ажиллуулах нөхцөл боломжийг хангасан. Ариутгал цэвэрлэгээг 2 удаа орчны цэвэрлэгээг 3 удаа хийлээ. Түлээ нүүрсийг 3 удаа татан нөөцөлсөн.

Эрүүл мэндийн чиглэлээр: Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авах арга хэмжээ, журам тушаал зааврын , СОК-ын шийдвэрийн дагуу эмч эмнэлгийн ажилчид 20 хүнд дотоодын сургалыг 3 удаа хийж заавар зөвлөмж, холбогдох журмыг танилцуулсан. Эрүүл мэндийн төвийн хүний нөөц, хүн амын судалгааг байгууллагын ажилчдыг хуралаар хэлэлцэж, тэтгэвэрт гарсан болон хүүхдээ асарч байгаа, өөр байгууллагад ажилладаг эмнэлгийн эмч мэргэжилтний судалгааг гаргаад байна. ЭМТ нь Амбулоторын байрыг бүрэн суллаж халдвартын бүтэн птокс бэлдэн ажиллаж байна. Тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангахад түргэн элэгдэх бараа материал 150000 төгрөг , эм эмнэлэгийн хэрэгсэлд 11 сая төгрөг зарцуулсан.

ЭМТ нь 525 мянган төгрөгөөр хамгаалалтын гутал, халууны шил, 1 удаагийн бээлий, био 00-245.0, хүчилтөрөгийн аппарат 700.0 мянган төгрөгөөр тус тус аваад байна.

Сумын ЭМТ-д Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөл 580.0 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл, нутгийн уугуул иргэн Р.Бөхбат 4ш хамгаалалтын хувцас,3 нүдний шил, "Бат бэх найрамдал хоршооноос 1 удаагийн маск 200ш, утлагын аппарат 2ш-ийг тус тус хандивлаад байна.

Аймгийн онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу байгууллагууд тусгаарлах өрөө бэлдсэн. ЗДТГ- 2 ортой 1 өрөө, тусгаарлах өрөөний ариутгал, халдваргүйтгэлийн бодис хэрэглэгдэхүүний зардалд 697.0 мянган төгрөг зарцуулаад байна. ЕБС - 12 ортой 3 өрөөг дотуур байрандаа бэлдээд байна. Ариутгал халдваргүйтгэлийн бодис хэрэглэгдэхүүний зардалд 50.0 мянган төгрөг зарцуулаад байна. Хүүхдийн цэцэрлэг- 2 ортой, 2 өрөө тусгаарлах өрөөгөөр бэлтгэж, 60.0 мянган төгрөгийн зардлаар ариутгал халдваргүйтгэлийн бодис хэрэглэгдэхүүнд зарцуулаад байна. Соёлын төв- 3 ортой, 1 өрөө бэлтгэж, 65.0 мянган төгрөгийн зардал гаргаад байна.

Эрүүл мэндийн яамнаас коронавирусын цар тахлын хүрээнд Covid-ийн сургагч багш бэлтгэх 2 хоногийн сургалтад Эрүүл мэндийн төвийн дарга хамрагдсан. Худалдаа үйлчилгээний газруудад Зай барь, Маскаа Зүүцгээе, тэмдэг тэмдэглэгээ болон коронавирусын тараах материалыг тараасан.

Эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдал эрүүл ахуй, халдвар хамгаалал,эрүүл мэндийг дэмжих ,ажиллах нөхцөлийг бүрдүүлж дэмжлэг үзүүлэх, дархлааг дэмжих ажлын

хүрээнд ажилчдад аарц, Чацаргана, Салимон, Витамин Д, 1 удаагийн амны хаалтаар хангаж ажиллалаа.

Түмэнцогт:

Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажил, арга хэмжээ энэ сард бүрэн зогссон. ОНХСангийн хөрөнгөөр 2-р багийн төвийн засвар, нүүлгэн шилжүүлэлт, Хог хаягдлын менежментийг сайжруулж, хогийн нэгдсэн цэгт эмнэлгийн аюултай хог хаягдлын устгалын цэг байгуулж зориулалтын дагуу тэмдэгжүүлэх ажил, 4-р багийн тоглоомын талбайг засварлах ажил, төв талбайн тохижилт лед дэлгэц, 3-р багийн хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны дээвэр засвар, төв зам дагуух гэрэлтүүлгийн ажлуудын санхүүжилтийг бүрэн хийж гүйцэтгэсэн.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн шуурхай штабаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд энэ сард 11 захирамж, 2 албан даалгавар, МУ-ын ЗГ-ын 6 тогтоолыг хэрэгжүүлэн зохион байгуулж 450 гаруй зөвлөмж чиглэл өгч ажилласан.

Байгаль орчны чиглэлээр: Төлөвлөгөөт бус хяналт шалгалт 6 объектод зөвлөн туслах үйлчилгээ, 3 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг тус тус хийж, хяналт шалгалтын удирдамж-9, зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөр-3, албан шаардлага 3, албан тоот 7 тус тус үйлдэж ажиллалаа.

Хяналт шалгалтын явцад нийт давхардсан тоогоор 5 зөрчил илэрч, 3 зөрчил арилгуулсан ба илэрсэн зөрчлийг арилгуулах хүрээнд, 12 заалттай 3 албан шаардлага, 2 аж ахуйн нэгжид хялбаршуулсан журмаар 3.000.000 төгрөгний торгууль, ногдуулж барагдуулалт 100 хувьтай байна.

Хууль бус ашигт малтмал олборлох, байгалийн нөөц баялаг түүх, ашиглах, Түгээмэл тархацтай ашигт малтмал хууль бусаар ашиглах, Хог хаягдлын тухай хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 17 асуудлаар 120 гаруй иргэн, 26 аж ахуйн нэгжид гарын авлага, брошур тарааж түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласний төлөр 2 ААНэгжээс 1.100.000 төгрөг, Хог хаягдлын төлбөр 3 ААНэгжээс 2.700.000 төгрөгийг татварын дансанд төвлөрүүлсэн.

Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр: Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 19-р тогтоолын дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Сумын аюулгүй нөөцөд 125 тн, гар тэжээл, хужир шүү 179 тн-ыг тус тус бэлтгээд байна. Сумын нутаг давсгэрт 2 багийн хадлан гарч 128 малчин, мал бүхий иргэдэд 19 нуруу өвсийг хямдралтай үнээр худалдан борлуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр гүн өрмийн худаг 3 -ыг гаргасан.

Коронавирустай холбоотой гарсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор дээрээс гарсан шийдвэрийн дагуу суманд үйл ажиллагаа явуулж байгаа 2 караоке, барны үйл ажиллагааг бүрэн зогсоосон бөгөөд хүнсний худалдаанаас бусад тусгай зөвшөөрөлтэй болон нийтийн хоол үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжийн ажиллах цагийн хуваарийг 08.00 цагаас 20.00 болгон тогтоосонтой холбоотой цагдаагийн байгууллага хяналт тавин ажиллаж байна. Мөн ариутгал халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутамд хийх, амны хаалтыг тогтмол хэрэглэх, амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй байх шаардлагатай бол камерийн бичлэгийг ухрааж үзэн хяналт тавин ажиллаж байхыг анхаарууллаа.

МХГазрын зөвлөмжийн дагуу 2 м зай барь болон сумын шуурхай штабын албан тоотыг төсөвт 5 байгууллага, 3 ШТС, 2 банк, 16 ААНэгж дэлгүүрүүдэд танилцуулж хүргүүлэн ажилласан. Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Тамир” ресторанд удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж заавар зөвлөгөө өгч ажилласан.

COVID-19 цар тахалтай холбогдуулан “Бадрах жаргал” ХХК, “Үргэлж жаргал” ХХК гэсэн 2 ААНэгжтэй Гамшгийн үед хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв: Энэ сард голомт бүхий бүс нутгаар зорчсон 198 иргэнийг татан авч гэрийн ажиглалтанд авч тогтмол хянаж ажиллалаа.

Ковид-19 халдварын бэлэн байдлыг ханган нөөц бүрдүүллээ.

Соёлын төв: 2020 онд Ковид цар тахалтай холбоотойгоор Түмэнцогт Соёлын төв нүүр номын хуудсаар дамжуулан хүн бүрийн заавал хөтлөх Угийн бичгийн сургалт хичээлийг цувралаар, соёл урлагийн талаарх цаг тухай бүрийн мэдээллийг лайв хэлбэрээр, иргэдийн дархлааг дэмжих бүжгийн цуврал сургалт хичээлээр, Соёлын биет бус өв тээгчдийг

алдаршуулах сурталчлах зорилгоор нутгийн яруу найргийг цуврал болгон подскат бүтээл зэргээр төрөл бүрийн арга хэмжээг шинээр санаачилан зохион байгуулж ажиллалаа.

Хорио цээр тогтоосны улмаас соёлын өвүүдийн талаархи суртачилгаа мэдлэг мэдээллийг иргэдэд Соёлын төвийн болон Түмэнцогт сумын нүүр хуудсаар иргэдэд цахим мэдээллийг хүргэж Түмэнцогт суман дахь байгалийн өвөрмөц тогтоц бүхий хад чулуу, уул овоог тайлбар зургийн хамт хүргэж чулуун соёлын өвийн мэдээллийг гарын авлага танилцуулгаар хүргэхэд уг мэдээллийг давхардсан тоогоор 215 хүн хандалт хийсэн байна.

2020 оны байдлаар **111** арга хэмжээ зохион байгуулагдсанаас **87** өөрийн бие даан зохион байгуулсан үйл ажиллагаа /56 арга хэмжээ нь цахим үйл ажиллагаа/ бол **24** арга хэмжээ нь бусад иргэд, байгууллагын үйл ажиллагааг хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн уран бүтээл, тоглолт 25, уралдаан тэмцээн 13, урлагийн 5 төрлийн дугуйлан /бүжиг 38, цэнгээнт бүжиг 40, уран уншлага 15, залуу номын санч клуб 12, 100 буудалт даамны 42/, соёл урлагийн явуулын үйлчилгээ 1, үдэшлэг хөтөлбөрт арга хэмжээ 3, номын сангийн үйлчлүүлэгч 687, музей үйлчлүүлэгч 1015 хүнд үйлчилж, 10 төрлийн видео дүрс бичлэг хийгдэж, сургалт 3, бусад 25 арга хэмжээ зохион байгуулагдаж давхардсан тоогоор нийт **29247** хүн хамрагдсан байна

Сургууль: Цар тахлын улмаас хөл хорио тогтоосон үед Сургуулийн “Хүүхэд хамгааллын баг” санаачлан “Залуу багш нарын холбоо”-той хамтран “Өндөр эрсдэлтэй” суралцагчдаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийнхаа нийт 57 багш ажилчдын дунд 1 хоногийн хандивын аян өрнүүлж, хувцас, өргөн хэрэглээний хүнсний зүйл ахуйн хэрэглэл, түлээ, нүүрс авч 4 сурагчийн гэр бүлд тусламж дэмжлэг үзүүллээ. Мөн дархлааг дэмжин аарц, чацаргана, санитол, маск зэргийг өгсөн.

Эрсдэлт бүлгийн 4 сурагчийн өрхийн амжиргаа, дархлааг дэмжих зорилгоор өрх бүрд 224,900 төгрөгийн хүнс, ахуйн хэрэглээний бараа, нэг сурагчийн теле хичээлээ үзэх боломжийг бүрдүүлэн зурагтай болгон, дулаан гэртээ цахим теле хичээл үзэх боломжоор ханган 1 машин түлээ нүүрсийг өгч сэтгэлийн дэм үзүүлэн ажилласан нь маш үр дүнтэй арга хэмжээ болсон.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: 2020 оны 11 сарын байдлаар шинээр ажлын байраар хангагдсан 33 иргэн байна. Төсөл хөтөлбөрт 24 иргэн, Уул уурхайд 5 иргэн, сумын хот тохижилтын ажилд 2 иргэн, төрийн албанд 2 иргэн орж шинэ ажлын байраар хангагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зарлагдсан төсөл хөтөлбөрүүдийн иргэдэд цахимаар мэдээлэл хүргэж гарын авлага тараасны үр дүнд нийт 15 төсөл хүлээн авч ХХҮГазарт хүргүүлснээс 9 төсөл дэмжигдэж гэрээ байгуулан санхүүжилт олгох холбогдох материалыг ХХҮГазарт хүргүүлсэн. Үүнд:

Нийгмийн халамжийн чиглэлээр: Нийгмийн халамжийн сангаас 1-11 сарын байдлаар 329,479,290 төгрөгний тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн санхүүжилтийг олгосон байна.

Халзан:

Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр: ИТХ-ын ээлжит бус 2 дугаар хуралдаан 2020 оны 12 сарын 1-ний өдөр хуралдаж сумын Амжиргаа дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөх, Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын зөвлөлд өөрчлөлт оруулах, сумын 2020 оны төсөвт тодотгол хийх асуудлыг хэлэлцэн тогтоол баталлаа.

Сумын ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдаанаар

1. Сумын Засаг даргын 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
2. Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
3. Сумын 2021 оны хөгжлийн төлөвлөгөө
4. Сумын 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2021 оны төсвийн төсөл
5. Сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө
6. Халзан Дулаан ОНӨУ газрын 2021 оны нийгэм эдийн засгийн үзүүлэлт, бүтэц орон тоог батлах тухай.
7. Бусад гэсэн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр: 2020 оны жилийн эцсийн хүн ам, мал тооллогын ажлыг сумын Засаг даргын 12 сарын 17-ны өдрийн 121-р захирамжаар 12 сарын 18-наас 28 хүртэл 10 хоног зохион байгуулж, багууд тооллогондоо гараад байна.

Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой Комиссын тогтоол, шийдвэрүүд болон аймгийн Засаг даргын 2020 оны А/126, А/154, А/160, А/161 А/163, А/174, А/198, А/253, А/588, А/592, А/594 дугаар захирамж, Засаг даргын 01, 03, 05, 06 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлж дараах ажлуудыг зохион байгуулж ажиллаж байна. Сумын хэмжээнд нийт шуурхай жижүүрийн 1 ээлж, хөдөлгөөнт 1 ээлж тус тус ажиллаж байна. Мөн Халзан сум шинэ зар групп –ээр Улаанбаатар хот болон бусад аймагруу зорчихгүй байх, Ковид-19 халдварын дамжих зам, урьдчилан сэргийлэх арга, хэмжээний талаархи мэдээллийг хүргэж ажилласан.

Аймгийн шуурхай штабын skype хаягаар ирсэн сумдын орж гарсан тээврийн хэрэгслийн судалгааг хүргүүлсэн.

Ковид 19 тай холбоотой гарсан Аймгийн Засаг даргын захирамжуудын биелэлтүүдийг өдөр бүр авч аймгийн ХШУДА хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Төсөв, санхүү: Сумын ИТХ-ын ээлжит бус 2-р хуралдаан 12 сарын 01-нд болж, 2020 оны төсөвт тодотгол хийж, Засаг даргын нөөц сангийн зардлыг 4000,0 сая төгрөгөөр, Гамшгаас хамгаалах зардлыг 9000,0 сая төгрөгөөр тус тус тодотгосон.

Сумын ИТХ-ын ээлжит 3-р хуралдаан 12 сарын 18-нд болж, 2021 оны төсөв батлагдсан. Татварын орлогоор 40200,0 мян/төг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 555983,8 мян/төг, урьд оны үлдэгдлээс 25000,0 сая/төг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5000,0 сая/төг, сум хөгжүүлэх сангийн орлогыг 120000,0 сая/төг, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 41933,1 мян/төг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 1068520,9 мян/төг нийт 1856637,8 мян/төг рөгөөр тус тус тооцож батлуулсан.

Хууль эрх зүйн ажлын хүрээнд: Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан аймгийн ХОХБТ-ийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ундрахаас цахимаар сургалт авсан. Боловсролын багц хуулийн санал авах цахим хэлэлцүүлэгт 4 багш хамрагдсан. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан Эрх зүйн хөтөч бэлтгэх цахим сургалтад ЕБС ийн насан туршийн боловсролын багш, ЗДТГ-ын эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нар хамрагдлаа. Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтуудын цахим сургалтад ЗДТГ –ын эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн тус тус хамрагдлаа.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

ЕБС: Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа сурагчдад дэм болох үүднээс сургуулийн хүүхэд хамгааллын хамтарсан баг, байгууллагын эцэг эхийн зөвлөл хамтран “Туслъя, Дэмжье” аяныг өрнүүлэн ажиллаж байна. Аяны хүрээнд 16 сурагчдад 523000 төгрөгний хоол хүнсний дэмжлэг үзүүлсэн.

Сургуулийн хүүхэд хамгааллын баг болон байгууллагын эцэг эхийн зөвлөл хамтран хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар брошур, гарын авлага бэлтгэн, эцэг эх асран хамгаалагч нарт тараан өгсөн. АУБ нараар дамжуулан нийт 85ш гарын авлагыг иргэдэд өгсөн. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй 8 сурагчийг хамтарсан багийн гишүүд хуваарийн дагуу тогтмол эргэж, эргэх холбоотой ажиллаж байна.

МУЗГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 188 дугаар “Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоол, БСШУС-ын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А\162 дугаар “Хүнсний дэмжлэг үзүүлэх тухай” тушаалын дагуу ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд зарцуулахаар нөөцөлсөн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг сургуулийн насны болон ЕБС-д 3 ба түүнээс дээш хүүхэд нь суралцдаг өрх мөн зорилтот бүлгийн 25 өрхийн хүүхдүүдэд 58800 төгрөгний багц нийт 1470000 төгрөгний дэмжлэгийг үзүүлсэн.

Хөршийн холбоог сайжруулах зорилгоор хамтарсан багийн гишүүд “Хөрш амгалан бол хүмүүн амгалан” цахим үйл ажиллагааг өрнүүлэн ажиллаж байна. Хөл хорионы үед гэртээ халуун, дулаан уур амьсгалыг бүрдүүлж, хөрш айлын хүүхдүүдээ ч марталгүй анхаарал хандуулан, гэр бүлийн ая тухтай, амар амгалан орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд “Айл хүний амь нэг саахалт айлын санаа нэг” уриа дэвшүүлж, хамтран ажиллаж байна. Эрсдэлт өртөж болзошгүй сурагчдын гэрээр гэрийн эргүүлийг тогтмол хийн, хойд аав ээжтэй болон архины хамааралтай гэр бүлд амьдардаг сурагчдын хөрш айлын утасны дугаарыг авч, хяналт тавин ажилласан.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн Жирэмсэн эхийн- 6, хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдах шинээр төрсөн 13 хүүхэд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрийн-2, Шинээр тогтоогдсон байнгын асаргаа шаардлагатай тэтгэмжийн-1, Түлээ нүүрсний хөнгөлөлт Ахмад Донор 1, Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдийн сунгалтын материалыг нийгмийн халамжийн WAIS-програмд шивж баталгаажуулан Хөдөлмөр эрхлэлт халамж үйлчилгээний газарт явуулсан.

ЖДҮ, СХСангийн талаар: 2020 оны 12-р сарын 23-ны байдлаар нийт 19 зээлдэгч байгаагаас 2020 оны 12 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 6 хүнээс 1,073,000 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Байгаль орчны чиглэлээр: Баян шарга уулын орчмын 190887.965 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай тогтоолын төслийн боловсруулан сумын ИТХ-ын 3 дугаар хуралдаанд оруулсан.

Эрдэнэцагаан:

Удирдлага зохион байгуулалт, хууль эрх зүйн хүрээнд: Сумын хэмжээнд голомттой бүсээс ирсэн 393 иргэнийг гэрийн тусгаарлан ажиглалтад хяналт тавиулахаар ЭМТ, Цагдаагийн тасаг, ГУА-47 дугаар анги, БЗД нар Төсвийн байгууллагын 84 албан хаагчийг томилгоожуулан хуваарилж өдөр бүр утсаар ярьж, гадуур 3, 3 хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлгийн эргүүл ажиллуулж одоогийн байдлаар гэрийн тусгаарлалт ажиглалтын хугацаа дуусаагүй 17 иргэн байгаагийн насан хүрэгчид 13, хүүхэд 4 байна.

Аймгийн ЭМГ-ын даргаар ахлуулсан бүлэг “Сумын эрсдэлийн үнэлгээ хийх, түүний тодотгол” зэргийг шалган туслах зорилгоор 2 хоног ажиллаа.

2020 оны Жилийн эцсийн сумын хүн ам, мал тооллогын ажлыг СЗД-ын 2020 А/231 дугаартай захирамаар 12 бүлэг 49 хүний бүрэлдэхүүнтэй, 2.7 сая төгрөгний зардалтай томилон ажиллуулж багуудын өрх хүн ам малыг тоолж дуусаад нэгтгэл тайлангаа хийж байна. Урьдчилсан байдлаар хүн ам 6884 байна.

Шинээр томилогдсон сумын Засаг дарга Г.Эрдэнэчулууны ажлыг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан баг ирж хүлээлцүүлсэн.

Сумын ээлжит ИТХ хуралдаж 2020 оны сумын ЗДТГ-ын хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын тайланг сонсож хангалттай гэсэн үнэлгээ өгсөн байна.

Хүүхдийн 2-р цэцэрлэг: Бүлгийн 5 багш, туслах багш 5, нийт 10 багш тус бүртээ теле хичээл бэлтгэсэн ба цахим хуудсанд байршуулж нийт хүүхдүүд, эцэг эхчүүддээ үзүүлэн нийт 135 хандалт авсан.

Архины хамааралтай 1 ээжид 2 удаа гэрийн эргэлт хийн заавар зөвлөгөөгөөр хангасан. Мөн тус өрхөд 3 тн нүүрс, амны хаалт 20 ширхэг, хүнсний зүйл, ариутгалын бодис, зорилтот бүлгийн 2 хүүхдийн ар гэрт амны хаалт 20 ширхэг, гар ариутгагч, шингэн саван, ургамлын тос, хүүхдийн будаа, 2 дүгээр багийн харъяа зорилтот бүлгийн 1 өрхөд 3 тн нүүрс гэх мэт зүйлийн тусламж олгосон.

FOOD BANK аянд нийт 360.000 төгрөгийн хүнс хандивласан байна.

Соёлын төв: Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан энэ сард олон нийтийг хамарсан үйл ажиллагаа болоогүй.

Энэ сард Өөрийн цахим хаягт Эрүүл мэндийн чиглэлээр тавьсан мэдээллийн тоо -12, Соёл урлагийн чиглэлээр – 36 тус тус байршуулсан.

Энэ сард номын сангаар 19 хүн үйлчлүүлсэн ба нийтдээ 26 ширхэг номоор үйлчилсэн байна. Онц байдал зарласантай холбогдуулан цахим орчинд мэдээ мэдээлэл давхардсан тоогоор зөвлөмж 14 удаа,Соёлын олон талт мэдээ мэдээллийг 36 удаа түгээн ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв: Тус сумын Эрүүл мэндийн төв нь нийт 6784 хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн яаралтай, нэн яаралтай тусламж үйлчилгээг ДЭМБ-ын хэнийг ч орхигдуулахгүй зарчимаар чанартай жигд хүртээмжтэй хүргэн ажиллаж байна. Анхан шатны тусламж үйлчилгээний чиглэлээр Хүн амд урьдчилан сэргийлэх болон идэвхитэй хяналтын үзлэгийг эмч нарын үзлэгийн хуваарийн дагуу нийт 834 хүнд үзлэг хийснээс , 2285 урьдчилан сэргийлэх үзлэгт , идэвхитэй хяналтаар 136 , стационараар нийт 198 хүнийг хэвтүүлэн эмчлүүлээд байна.

2020 оны 12-р сарын байдлаар 146 эхийг жирэмсний хяналтад авч 136 эхийг эхний 3 сартай хяналтанд хамруулснаар жирэмсний эрт хяналтын хувь 94 % байна. 2020 оны 12 сарын байдлаар сэргээн засах эмчилгээгээр нийт 20 хүн эмчлүүлсэн. Дархлаажуулалтын хүрээнд сургалт 128 хүнд сургалт сурталчилгаа хийж зөвлөгөө өгөв.

Коронавируст халдвар /ковид -19/ын цар тахалтай тэмцэх халдвараас урьдчилан сэргийлэх эрсдлийг бууруулах зорилгоор ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад коронавируст халдвар болон томуу , томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж зөвлөгөө өгч цахим хуудас албан байгуулагуудын цахим хаягаар байршуулсан.

Эрдэнэцагаан Эрүүл мэндийн төвөөс Цахим орчинд Маскаа зүүе, гараа угаая, зай барь, томуу томуу төст өвчнөөс сэргийлэх зөвлөлөгөө зөвлөмжийг байршуулан ажиллаж байна.

Эрүүл мэндийн төвийн эмч эмнэлгийн ажилчдад хамгаалах хувцас өмсөх тайлах дарааллаар өдөр болгон хуваарийн дагуу дотоодын сургалтыг хийж байна.

Ариутгал халдваргүйтгэлийг өдөр бүр эрүүл мэндийн төвийн 3,037 м³кв талбайд хийж бусад газруудад нийт 4,090 м³кв талбайд тус тус хийж гүйцэтгэлээ.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар